

ГАДААД ХАРИЛЦААНЫ

# СЭРГЭЭЛТ

2023-2024



United nations  
climate change



COP28UAE

МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХЭНД АЛТАН  
ҮСГЭЭР БИЧИГДЭХ АЙЛЧЛАЛУУД

**1 ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА**

- 6 НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 78 дугаар чуулганд оролцов
- 10 Ойрын 10 жил шинжлэх ухаан, технологи, инновацийн шинэ сэргэлтийн үе байх болно
- 12 Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалт болов
- 14 Олон улсын монголч эрдэмтдийн ээлжит хурал болов
- 16 Нэгдсэн Үндэстний Байгууллагын өдрийг тэмдэглэв
- 18 НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын талуудын 17 дугаар бага хурал 2026 онд Монголд болно
- 20 Дэлхийн эмэгтэйчүүд Монголд чуулав
- 22 Дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө тууштай хамтран ажиллахыг уриалав
- 26 "Ирээдүйн төлөө тогтвортой бэлчээр, газрын асуудлаарх олон улсын эвсэл" байгуулах санаачилга дэвшүүлэв
- 28 НҮБ-ын найм дахь Ерөнхий нарийн бичгийн дарга, Илүү сайхан ирээдүйн төлөө Бан Ги Мүн сангийн тэргүүн Бан Ги Мүнд "Чингис хаан" одон хүртээв

**2 МОНГОЛ УЛС БА БҮС НУТАГ**

- 34 "Бүс ба Зам" олон улсын хамтын ажиллагааны дээд түвшний чуулга уулзалтад оролцов
- 36 Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх БНХАУ-ын дарга Ши Жиньпintэй уулзав
- 37 Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтэй уулзав
- 38 ШХАБ-ын гишүүн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ

**3 ГАДААД УЛСЫН ТӨРИЙН ТЭРГҮҮН НАРЫН МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЙЛЧЛАЛ**

- 42 Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Анджей Дуда
- 44 Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макрон
- 46 Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч Садыр Нургожоевич Жапаров
- 48 Гэгээн Ширээт Улсын Төрийн тэргүүн Пап Францис
- 50 Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ИБУИНХУ-ын Цог Жавхлант Хаан III Чарльзыг хаан сэнтийд залах ёслолд оролцов
- 52 Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Колизеум театрт зочлов
- 53 "Монгол хаан" жүжгийг Лондон хотын Колизеум театрт тоглов
- 54 Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэр
- 56 Герман – Монгол толь бичгийн судлал дахь "Шинэ олдвор"
- 57 Монгол охины нэрээр нэрлэгдсэн герман шоколад
- 58 Бүгд Найрамдах Беларусь Улсын Ерөнхийлөгч Александр Григорьевич Лукашенко
- 60 Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгч Тонглун Сисүлит

- 62 Бутаны Хаант Улсын Цог Жавхлант Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчук
- 66 Швейцарын Холбооны Улсын Ерөнхийлөгч Виола Амхерд
- 68 Бүгд Найрамдах Словени Улсын Ерөнхийлөгч Наташа Пирц Мусар
- 70 Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путин
- 72 Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч То Лам
- 74 Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев

**4 МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ТЭРГҮҮНИЙ ГАДААД УЛСАД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЙЛЧЛАЛ**

- 78 Бүгд Найрамдах Франц Улсад төрийн айлчлал хийв
- 80 Морин хуурын чуулга Версалийн ордонд тоглов
- 81 "Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь" үзэсгэлэнг нээв
- 82 Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад төрийн айлчлал хийв
- 84 Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад төрийн айлчлал хийв
- 86 Бүгд Найрамдах Узбекистан Улсад төрийн айлчлал хийв
- 88 Туркменистан Улсад төрийн айлчлал хийв
- 90 "Парис-2024" зуны Олимпын нээлтэд оролцов

**5 БАЙР СУУРЬ**

- 94 **Б.Батцэцэг:** Эмэгтэйчүүдийн дуу хоолойг дэлхий дахинд хүчтэй илэрхийлэх талбар болгохыг зорьж ажиллалаа
- 98 **Э.Одбаяр:** Монгол Улсын гадаад бодлогын амин зүрх нь харилцан ашигтай, тэнцвэртэй харилцаа
- 104 **Д.Баярхүү:** 2024 он Иж бүрэн түншлэлийн харилцааг шат ахиулсан жил боллоо
- 106 **Д.Гэрэлмаа:** Монгол Улс, Швейцарын Холбооны Улсын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломж бий
- 108 **Ц.Баатар:** Казахстан нь газар зүйн байршил, түүхэн уламжлалын хувьд ч бидний хамгийн ойрын гуравдагч хөрш
- 109 **Ж.Лхагвадэмчиг:** Монгол, Бутаны харилцаа алсдаа буддын шашин, аялал жуулчлалаар өргөжих болов уу
- 112 **Д.Ганболд:** Ямар ч бутан хүнтэй уулзахад "Бид монгол гаралтай" гэх юм билээ
- 113 Кубын удирдагч асан Раул Кастрогийн охин Мариэла Кастро Монгол оронд
- 114 Монгол морь нутгаа тэмцэж гүйсэн гайхамшигт түүх
- 115 **Д.Соулия:** Монголын зун, монголчуудын зүрх сэтгэл тийм халуун гэж огт төсөөлөөгүй

**2023-2024 онд Монгол Улсад хийсэн төрийн айлчлалууд**

- Польш:** Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Анджей Дуда 2023.4.24 - 26
- Франц:** Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макрон 2023.5.21 - 22
- Киргиз:** Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Н.Жапаров 2023.7.9 - 11
- Гэгээн Ширээт Улсын Төрийн тэргүүн Пап Францис:** 2023.8.31
- Герман:** Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэр 2024.2.7 - 8
- Швейцар:** Швейцарын Холбооны Улсын Ерөнхийлөгч Виола Амхерд 2024.8.2 - 4
- Беларусь:** Бүгд Найрамдах Беларусь Улсын Ерөнхийлөгч А.Г.Лукашенко 2024.6.1 - 4
- Лаос:** Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгч Тонглун Сисүлит 2024.6.11 - 12
- Словени:** Бүгд Найрамдах Словени Улсын Ерөнхийлөгч Наташа Пирц Мусар 2024.8.20 - 23
- Орос:** Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч В.В.Путин 2024.9.2 - 3
- Вьетнам:** Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч То Лам 2024.9.30 - 10.1
- Казахстан:** Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Кемелевич Токаев 2024.10.28-29




# ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА

“Монгол Улс олон улсын эрх зүй, НҮБ-ын Дүрмийг дээдэлсэн олон талт хамтын ажиллагааг бэхжүүлэх нь олон улсын энх тайван, аюулгүй байдлыг хангах гол арга зам хэмээн үздэг бөгөөд түүний дотор яриа хэлэлцээ, харилцан ойлголцол, харилцан итгэлцлийг бэхжүүлэх нь дэлхий нийтийн тогтвортой байдал, энх тайвнаар зэрэгцэн орших гол үндэс суурь юм”

*Монгол Улсын Ерөнхийлөгч  
У.Хүрэлсүхийн хэлсэн үгээс*



# НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 78 дугаар чуулганд оролцов



2023.9.19-23

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ 2023 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 19-23-НЫ ӨДРҮҮДЭД АНУ-ЫН НЬУ-ЙОРК ХОТНОО АЖИЛЛАЖ, НҮБ-ЫН ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙН 78 ДУГААР ЧУУЛГАНЫ ЕРӨНХИЙ САНАЛ ШҮҮМЖЛЭЛД ОРОЛЦОВ.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтыг Монгол Улсад 2024 онд зохион байгуулах саналыг дэвшүүлж байгаагаа хэллээ. Уг санаачилгыг дэлхийн улс орнууд дэмжин ажиллахыг уриалав.

Уур амьсгалын өөрчлөлт хүн төрөлхтний амьдралд аюулын харанга дэлдэж, эх дэлхийн оршин тогтнохуйд түгшүүрийн дохио хангинуулж байгаа энэ үед Монгол Улс гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн томоохон шинэчлэл хийснээр 2023 онд "Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксаноми"-ийг баталсан дэлхийн анхдагч

**Үргэлжлэл VIII нүүрт**

“Монгол Улс бол зөрчил тэмцэлтэй дэлхий ертөнцөд энх тайвны бэлгэ тэмдэг болсон улс.”

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш



НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Амина Мохаммедын хамт



НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагын гүйцэтгэх захирал Сима Бахусын хамт



НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Ибрахим Тиогийн хамт

### Монгол Улс ба Нэгдсэн Үндэстний Байгууллага

#### Түрүүч нь VI нүүрт

орнуудын нэг болсон.

Мөн "Тэрбум мод", "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлж байгаагийн зэрэгцээ ногоон, цахим, хүртээмжтэй худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор "Дэлхийн экспортыг дэмжих чуулга уулзалт"-ыг эх орондоо амжилттай зохион байгуулсныг хэллээ. Түүнчлэн Ерөнхий Ассамблейн 78 дугаар чуулганаар баталсан эрүүл мэндтэй холбоотой зорилтуудыг "Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхээ илэрхийлэв.

Орхоны хөндийд монголчуудын эртний нийслэл Хархорум хотыг байгаль орчинд халгүй, ногоон хөгжилд тулгуурласан ухаалаг-эко хот болгон сэргээн байгуулах их бүтээн байгуулалтын ажил эхлүүлсний зэрэгцээ НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг 2026 онд Улаанбаатар хотноо зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна. НҮБ дахь Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын бүлгийн дэд даргаар ажиллаж, Дэлхийн худалдааны байгууллага, Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагын хүрээнд ДГХБО-ын бүлгийг байгуулах санаачилгыг дэвшүүлэн хэрэгжүүлж байгаагаа дурдав.

Олон улсын харилцааны дэг журам, хэм хэмжээ эрс өөрчлөгдөж буй цаг үед НҮБ-ын шинэчлэлийг эрчимжүүлэх, ялангуяа НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шинэчлэлийн яриа хэлэлцээг урагшлуулахад гишүүн улс орнууд идэвх санаачилгатай оролцох нь чухал хэмээн Монгол Улс үзэж байгаагаа илэрхийллээ.

НҮБ болон олон талт хамтын ажиллагаан дахь энхийн төлөөх хүчин чармайлтын хүрээнд, өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд Монгол Улс 20 мянга гаруй энхийг сахиулагчаа дэлхийн халуун цэгт илгээж, хүн төрөлхтний

энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалахын төлөө дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэйгөөр биелүүлж ирсэн. Цаашид НҮБ болон түүний системийн байгууллагуудын санаачилга, үйл ажиллагааг бүрэн дэмжиж ажиллахаа илэрхийллээ.



Швейцарын Холбооны Улсын Холбооны Ерөнхийлөгч Ален Берсегийн хамт



Бүгд Найрамдах Чех Улсын Ерөнхийлөгч Петр Павелын хамт



Бүгд Найрамдах Словени Улсын Ерөнхийлөгч Наташа Пирц Мусарын хамт



Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч Юн Сог Ёлийн хамт



Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаевын хамт



Япон Улсын Ерөнхий сайд Фүмио Кишидагийн хамт

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оноос хойш жил бүр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн Ерөнхий санал шүүмжлэлд оролцож байна.



Хөгжиж буй орнуудын 77-гийн бүлгийн төр, засгийн тэргүүн нарын дээд түвшний уулзалт - 2023

## Ойрын 10 жил шинжлэх ухаан, технологи, инновацын шинэ сэргэлтийн үе байх болно



2023.9.15-16

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БҮГД НАЙРАМДАХ КУБА УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ МИГЕЛЬ ДИАЗ-КАНЕЛ БЕРМУДЕСИЙН УРИЛГААР 2023 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 15-16-НЫ ӨДРҮҮДЭД ХАВАНА ХОТНОО БОЛСОН ХӨГЖИЖ БҮЙ ОРНУУДЫН 77-ГИЙН БҮЛГИЙН ТӨР, ЗАСГИЙН ТЭРГҮҮН НАРЫН ДЭЭД ТҮВШНИЙ УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ.

Монгол Улс "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтээ олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, инновацын тогтолцоог бүрдүүлэхээр тусгаж, ойрын 10 жилийг шинжлэх ухаан, технологи, инновацын шинэ сэргэлтийн он жилүүд болгохоор ажиллаж байгааг Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хэллээ. Монгол Улс сүүлийн жилүүдэд цахим шилжилтийг

эрчимжүүлж, Цахим хөгжлийн багц хуулийг баталж, төрийн үйлчилгээг хялбаршуулан, иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих, авлига, хүнд суртлыг бууруулах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор E-Mongolia системийг улс орон даяар амжилттай нэвтрүүлсэн бөгөөд 2022 онд Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг шинээр байгуулан "Цахим үндэстэн" болохыг



Төр, засгийн тэргүүнүүдийн хамт

зорьж байна. Мөн шинжлэх ухаан, технологийн салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, чадавхыг сайжруулах зорилгоор Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн нэгдсэн цогцолборын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлж, Шинжлэх ухаан, технологийн паркийг эрчимтэй хөгжүүлэхийг зорьж буй.

Цаашид Монгол Улс тогтвортой хөгжлийн зорилгуудыг ханган хэрэгжүүлэхэд чиглэсэн шинжлэх ухаан, техно-

логийн дэвшлийг хуваалцах, инновацыг дэмжих, бүс нутгийн тулгамдсан сорилтуудыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа шинжилгээ, төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх зэргээр шинжлэх ухаан, технологийн салбарт 77-гийн бүлгийн гишүүн улсуудтай хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлэв.



Хөгжиж буй орнуудын 77-гийн бүлгийн дээд түвшний уулзалтын үеэр



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Куба Улсад суралцаж буй оюутнуудтай уулзав.



Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалт - 2023



2023.6.29 - 30

# Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалт болов

МОНГОЛ УЛС ГАДААД ХЭРГИЙН ЭМЭГТЭЙ САЙД НАРЫН УУЛЗАЛТЫГ УЛААНБААТАР ХОТНОО 2023 ОНЫ 6 ДУГААР САРЫН 29-30-НЫ ӨДРҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛАВ.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх дэлхий ертөнцийн амар амгалан, аюулгүй байдлыг хангах, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд улс орнуудын эмэгтэй удирдагчдын үүрэг оролцоо, манлайлал нэн чухал болохыг тэмдэглэв.

Монгол Улс эмэгтэйчүүдэд чиглэсэн бодлогыг гадаад харилцаандаа тасралтгүй явуулж, жендерийн зааг ялгааг арилгахад чиглэсэн үйл ажиллагааг тогтмол дэмжиж ирсэн.

Энэхүү уулзалт нь Монгол Улсын



бодлого, байр суурийг таниулсан явдал төдийгүй жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн олон улсын

хамтын нийгэмлэгийн хүч чармайлтад оруулж буй бодит хувь нэмэр юм хэмээв.



## Олон улсын монголч эрдэмтдийн XII их хурал



2023.8.9 – 14

## Олон улсын монголч эрдэмтдийн ээлжит хурал болов

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН ИВЭЭЛ ДОР 2023 ОНЫ 8 ДУГААР САРЫН 9-14-НИЙ ӨДРҮҮДЭД ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТДИЙН ИХ ХУРАЛ УЛААНБААТАР ХОТНОО БОЛЛОО. ЭНЭХҮҮ ХУРАЛД 27 ОРНЫ 500 ЭРДЭМТЭН ОРОЛЦОВ. ТУС ХУРАЛ НЬ ОРОЛЦОГЧДЫНХОО ТОО, ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЦАР ХҮРЭЭ, ТОГТМОЛЖСОН БАЙДЛААРАА ДЭЛХИЙН АЛЬ Ч ОРОНД ЭНЭ ЧИГЛЭЛЭЭР БОЛДОГҮЙ ТОМООХОН ХУРАЛ ЮМ.

*Монгол Улс Олон улсын монголч эрдэмтдийн их хурлыг 1959 оноос хойш таван жил тутам зохион байгуулж байна.*

## Унгарын монголч эрдэмтэн Бирталан Агнеш

Монгол судлал өрнүүн хөгжиж байна. Гэхдээ монгол судлалыг дагалдах гэхээсээ бие даасан, сонгодог утгаар нь чиглүүлж явах хэрэгтэй. Сонгодог монгол судлал гэдэг нь монгол хэл, соёлыг олон талаас нь авч үзэж, судлахыг хэлнэ.

Зарим улс орон хятад, манж, төвөд зэрэг судлалыг дагалдуулж зөвхөн монгол хэл, соёл, түүх, угсаатны зүй зэрэг ганц нэг салбарыг хөгжүүлж буй нь дагалдах монгол судлал юм. Монгол орон, монголчуудын түүх соёлыг таниагүй хүн ултай, буурь суурьтай судалгаа хийх бололцоогүй. Дэлхий даяар өдгөө уламжлалт маягаар хэрхэн амьдрах вэ, амьд байгалийг сүйтгэхгүйгээр хэрхэн оршин тогтнох вэ гэсэн асуудлыг хөндөх болсон.

Монгол нүүдэлчдийн эртнээс хуримтлуулсан мэдлэг ойлголт, бүтээлч сэтгэлгээ хүн төрөлхтний ирээдүйд жинтэй хувь нэмэр оруулна гэдэгт эргэлздэггүй.





Монгол Улс ба Нэгдсэн Үндэстний Байгууллага

# Нэгдсэн Үндэстний Байгууллагын өдрийг тэмдэглэв

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН УЛААНБААТАР ХОТ ДАХЬ НҮБ-ЫН БАЙРАНД ЗОЧЛОВ. ЭНЭ ҮЕЭР ТЭРБЭЭР УРАН БАРИМАЛЧ А.ОЧИРБОЛДЫН "УХАМСАР" БҮТЭЭЛИЙГ НҮБ-ЫН ХАМТ ОЛОНД БЭЛЭГЛЭСЭН ЮМ.



2023.10.24



НҮБ, түүний төрөлжсөн байгууллагуудын Монгол Улсад явуулж буй үйл ажиллагаатай танилцав.



Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалт - 2023

## НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын талуудын 17 дугаар бага хурал 2026 онд Монголд болно

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 1-2-НЫ ӨДРҮҮДЭД ДУБАЙ ХОТНОО БОЛСОН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН АСУУДЛААРХ ДЭЛХИЙН УДИРДАГЧДЫН ДЭЭД ТҮВШНИЙ УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ.



2023.12.1-2



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт, дэлхийн дулааралтай тэмцэж буй бүх нийтийн хүч чармайлтад оруулж байгаа Монгол Улсын хувь нэмрийг нэмэгдүүлэхийг эрмэлзэж, энэ хүрээнд "Тэрбум мод", "Хүнсний хангамж, аюулгүй байдал", "Эрүүл монгол хүн" зэрэг хөдөлгөөнийг санаачлан орон даяар амжилттай хэрэгжүүлж байгаагаа илэрхийлэв.

Мөн 2026 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг Монгол Улс хүлээн авч зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байгаагаа дурдлаа.

Түүнчлэн Монгол Улс ирэх 2026 оныг "Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил" болгох НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолыг санаачлан батлуулснаа тодотгов.



АНЭУ-ын Ерөнхийлөгч Эрхэм дээд Шейх Мухаммад бин Заид Аль-Нахьянтай хийсэн уулзалтын үеэр



Унгар Улсын Ерөнхийлөгч Каталин Новактай хийсэн уулзалтын үеэр



"Дэ Нэйче Консерванси" байгууллагын гүйцэтгэх захирал Женнифер Морристой уулзав.



Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ерөнхийлөгч Шавкат Мирзиёевтой хийсэн уулзалтын үеэр



Монгол Улс ба Нэгдсэн Үндэстний Байгууллага

## Дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө тууштай хамтран ажиллахыг уриалав



2024.9.21-26

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ 2024 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 21-26-НЫ ӨДРҮҮДЭД НЬЮ-ЙОРК ХОТНОО АЖИЛЛАЖ, НҮБ-ЫН ЕРӨНХИЙ АССАМБЛЕЙН 79 ДҮГЭЭР ЧУУЛГАНЫ ЕРӨНХИЙ САНАЛ ШҮҮМЖЛЭЛД ОРОЛЦОВ. НҮБ-ЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА АНТОНИО ГУТЕРРЕШИЙН САНААЧИЛГААР ЗОХИОН БАЙГУУЛСАН ИРЭЭДҮЙН АСУУДЛААРХ ДЭЭД ТҮВШНИЙ УУЛЗАЛТААР "ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ ГЭРЭЭ", "ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН АСУУДЛААРХ ТУНХАГЛАЛ", "ДЭЛХИЙ НИЙТИЙН ЦАХИМ ХӨГЖЛИЙН ГЭРЭЭ" ЗЭРЭГ БАРИМТ БИЧГИЙГ БОЛОВСРУУЛАХАД МОНГОЛ УЛС ИДЭВХ САНААЧИЛГАТАЙ ОРОЛЦСОНЫГ ТЭМДЭГЛЭВ.



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн захирагч Аким Штайнерын хамт



Олон Улсын Улаан Загалмай Хорооны ерөнхийлөгч Мирьяана Эггерийн хамт



НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррешийн хамт

Орчин цагт Монгол Улс энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогыг тууштай баримталдаг орны хувьд дэлхийн улс орнуудын түүх, соёл иргэншил, шашин шүтлэг, үндэсний язгуур эрх ашиг, хөгжлийн замналаас үүдэлтэй олон ургалч үзлийг хүндэтгэн үзэж, олон улсын харилцааг олон тулгуурт зарчмаар цогцлоохыг эрмэлздэг. Энэ хүрээндээ Монгол Улс НҮБ-ын гишүүн бүх улс оронтой дипломат харилцаа тогтоосон бөгөөд дэлхийн бүх улс оронтой найрсаг харилцаа, хамтын ажиллагаагаа бэхжүүлэн хөгжүүлэхийн төлөө байгаагаа Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх илэрхийлэв.

Мөн аливаа улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолын эсрэг хүч хэрэглэхгүй байх тухай НҮБ-ын дүрмийн зарчмыг хэлбэрэлтгүй сахиж, санал зөрөлдөөн, зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэхдээ сөргөлдөөн бус дипломат яриа хэлэлцээ, дайсагнал бус эв нэгдэл, талцал хуваагдал бус хамтын үзэл санааг чанд баримтлан, дэлхийн энх тайван, аюулгүй байдлыг бэхжүүлэхийн төлөө тууштай хамтран ажиллахыг дэлхийн улс үндэстнүүдэд уриаллаа. Энх тайван, тогтвортой байдлыг хангах, ялангуяа цөмийн аюулаас ангид ертөнцийг бий болгохын төлөө бүх улс орон хамтран ажиллахыг уриалсны зэрэгцээ уг асуудлаар НҮБ-ын хүрээнд тусгай чуулга уулзалт зохион байгуулахыг санал болгов.



Нью-Йорк,  
НҮБ-ын төв байр,  
"Ухамсар" хөшөө



Испанийн Хаант Улсын Ерөнхий сайд Педро Санчезын хамт



Япон Улсын Ерөнхий сайд Фүмио Кишидагийн хамт



Бутаны Хаант Улсын Ерөнхий сайд Цэрэн Тобгайгийн хамт

Дэлхийн эмэгтэйчүүдийн анхдугаар чуулга уулзалт - 2024

## Дэлхийн эмэгтэйчүүд Монголд чуулав

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР "НОГООН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨ" СЭДЭВТ ДЭЛХИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТЫГ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР, ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ, НҮБ-ТАЙ ХАМТРАН 2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 22-23-НЫ ӨДРҮҮДЭД УЛААНБААТАР ХОТНОО ЗОХИОН БАЙГУУЛЛАА.



2024.8.22-23



Монгол Улс эмэгтэйчүүдийг чадавхжуулах, хүйсийн тэгш харьцааг хангах, эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлэх дэлхий нийтийн үйлсэд манлайлах болно.

НҮБ-тай хамтран зохион байгуулсан энэхүү чуулга уулзалтаар 19 улсын төр, засгийн тэргүүн, хууль тогтоох байгууллагын дарга, сайд, олон улсын 20 гаруй байгууллага, төрийн бус байгууллага, иргэний нийгэм болон бизнес, спорт, урлаг зэрэг салбарын манлайлагч 800 эмэгтэй чуулж, жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих, дэлхий дахинд тулгамдаж буй сорилтуудыг шийдвэрлэхэд эмэгтэйчүүдийн үүрэг, оролцооны асуудлаар өргөн хэлэлцүүлэг өрнүүлж, туршлага солилцов. Чуулга уулзалтын дүнгээр "Тогтвортой ирээдүйн төлөөх Улаанбаатарын тунхаглал"-ыг гаргалаа.



НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Амина Мохаммед



Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх Дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалт - 2024

## "Ирээдүйн төлөө тогтвортой бэлчээр, газрын асуудлаарх олон улсын эвсэл" байгуулах санаачилга дэвшүүлэв



2024.11.12-13

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БҮГД НАЙРАМДАХ АЗЕРБАЙЖАН УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ИЛЬХАМ АЛИЕВИЙН УРИЛГААР 2024 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 12-13-НЫ ӨДРҮҮДЭД ТУС УЛСЫН БАКУ ХОТНОО БОЛСОН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН АСУУДЛААРХ ДЭЛХИЙН УДИРДАГЧДЫН ДЭЭД ТҮВШНИЙ УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх "Хүн төрөлхтөн өнөөдөр эх байгалийг эрхшээх бус энэрэн хүндэтгэх нэгэн зорилго дор хамтын ирээдүйн төлөө нэгдэж, улс орон бүр илүү бодит үр дүнд хүрэхийн тулд төр, хувийн хэвшил, иргэний нийгэм зэрэг нийгмийн бүх бүлгийг хамарсан үндэсний хэмжээний зөвшилцөл, нэгдмэл бодлого, харилцан ойлголцлыг бэхжүүлэх шаардлагатай байна. Хэрэв хүн төрөлхтөн эх дэлхийгээ хамгаалж, уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, биологийн олон янз байдлын хомсдолтой цаг алдалгүй эрс шийдэмгий тэмцэхгүй бол эх дэлхий цаашид та бидэнгүйгээр оршин тогтнох өөрийн замаа сонгох болно.

Манай улс сэргээгдэх эрчим хүч, ногоон хөдөө аж ахуй, ойн салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор хууль эрх зүй, бизнесийн орчны цогц шинэчлэлийг хийж байна. Тухайлбал, манай улс "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, "Өнө мөнхийн Монгол" байгаль хамгааллын байнгын санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлээд байна. Уур амьсгалын өөрчлөлт нь уламжлалт бэлчээрийн аж ахуйд түшиглэсэн улс орнуудад сөргөөр нөлөөлж байгаа энэ цаг үед Монгол Улс "Ирээдүйн төлөө тогтвортой бэлчээр, газрын асуудлаарх олон улсын эвсэл" байгуулах санаачилгыг дэвшүүлж байна.


Энэхүү санаачилгыг дэлхийн улс орнууд дэмжсэнээр уламжлалт бэлчээрийн аж ахуйтай дэлхийн



Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхийлөгч Ильхам Алиевын хамт

100 гаруй улс орон руу чиглэсэн хөрөнгө оруулалт, санхүүжилт нэмэгдэж, 500 орчим сая хүний эрүүл мэнд, аж амьдралыг хамгаалан сайжруулахад бодит дэмжлэг болох юм.

Түүнчлэн энэхүү санаачилга нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан "2025 оныг Хоршооллын олон улсын жил болгон тэмдэглэх тухай", "2026 оныг Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуйн олон улсын жилээр зарлах тухай" тогтоолыг хэрэгжүүлэх болон НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг 2026 онд Улаанбаатар хотноо зохион байгуулах бэлтгэлийг хангахад чухал хувь нэмэр болно" хэмээн үзэж байгаагаа хэллээ.



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийг "Баку" цэнгэлдэх хүрээлэнд хүрэлцэн ирэхэд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Ерөнхийлөгч Ильхам Алиев нар угтав.



Монгол Улс ба Нэгдсэн Үндэстний Байгууллага

## НҮБ-ын найм дахь Ерөнхий нарийн бичгийн дарга, Илүү сайхан ирээдүйн төлөө Бан Ги Мүн сангийн тэргүүн Бан Ги Мүнд Монгол төрийн дээд шагнал "Чингис хаан" тэргүүн зэргийн одон хүртээв

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ЗАРЛИГ ГАРГАН, ИХ ЭЗЭН ЧИНГИС ХААНЫ МЭНДЭЛСНИЙ 862 ЖИЛИЙН ОЙ, "МОНГОЛ БАХАРХЛЫН ӨДӨР"-ИЙГ ТОХИОЛДУУЛАН НҮБ-ЫН НАЙМ ДАХЬ ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ИЛҮҮ САЙХАН ИРЭЭДҮЙН ТӨЛӨӨХ БАН ГИ МҮН САНГИЙН ТЭРГҮҮН БАН ГИ МҮНД МОНГОЛ ТӨРИЙН ДЭЭД ШАГНАЛ, "ЧИНГИС ХААН" ТЭРГҮҮН ЗЭРГИЙН ОДОН ХҮРТЭЭЛЭЭ.



2024.11.2 - 3

Улс түмний эв нэгдэл, хөгжил цэцэглэлт, хүн төрөлхтний амар амгалан байдлыг бэхжүүлэх болон Монгол Улс гадаад орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэлхий дахинд Монгол Улсын нэр хүндийг өргөн сурталчлах, тус улсын эдийн засаг, нийгэм, оюун санааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан гадаад орны төр, нийгмийн зүтгэлтэн, иргэнийг уг шагналаар шагнадаг. Бан Ги Мүн нь АНУ-ын эрдэмтэн Жак Уэтерфордын дараа "Чингис хаан" тэргүүн зэргийн одон хүртсэн хоёр дахь гадаад иргэн болов.







“一带一路” 国际合作高峰论坛绿色发展高级别论坛  
Belt and Road Forum for International Cooperation  
High-Level Forum on Green Development

2023年10月18日 中国·北京

18 OCTOBER 2023 BEIJING, CHINA



# МОНГОЛ УЛС БА БҮС НУТАГ

Олон улсын харилцааны хөгжил, дэлхийн болон бүс нутгийн улс төрийн нөхцөл байдалтай уялдуулан гадаад бодлогын чиглэл, зорилтыг уян хатан тогтооно.

*Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалаас*





“Бүс ба Зам” олон улсын хамтын ажиллагааны дээд түвшний чуулга уулзалт

## “Бүс ба Зам” олон улсын хамтын ажиллагааны дээд түвшний чуулга уулзалтад оролцов



2023.10.17 – 20

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 17-20-НЫ ӨДРҮҮДЭД БЭЭЖИН ХОТНОО БОЛСОН “БҮС БА ЗАМ” ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ДЭЭД ТҮВШНИЙ ГУРАВ ДАХЬ УДААГИЙН УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх тус чуулга уулзалтын үеэр зохион байгуулсан “Ногоон Торгоны замыг хамтдаа бүтээж, хүн ба байгалийн эв зохистой оршихуйг урагшлуулъя” хэлэлцүүлэгт оролцож, үг хэллээ.



Тэрбээр “Бүс ба Зам” санаачилга нь хөгжлийн боломжоо хуваалцах, харилцан суралцах, харилцан ашигтай, эрх тэгш хамтран ажиллах үзэл санаанд тулгуурлан “хамтдаа хэлэлцэх, хамтдаа бүтээх, хамтдаа үр

өгөөжөө хүртэх” үндсэн зарчмын дагуу хөгжлийн төлөөх хамтын ажиллагааг бүс нутгийн түвшинд өрнүүлэх чухал тавцан болж байгааг тэмдэглэв.

Энэ удаагийн чуулга уулзалтаар хамтран гаргаж байгаа “Бүс ба Замын ногоон хөгжлийн төлөөх Бээжингийн санаачилга” нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, цөлжилттэй тэмцэх, ногоон дэд бүтэц, ногоон

хөрөнгө оруулалт, санхүүжилтийг дэмжихэд чиглэсэн улс орнуудын хамтын ажиллагааг эрчимжүүлэх чухал ач холбогдолтойг тодотгов.


Монгол Улс “Тэрбум мод”, “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, “Эрүүл монгол хүн” үндэсний хөдөлгөөн өрнүүлж байгаа нь Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлж буй үйл ажиллагаа болохыг хэллээ.



Монгол Улс, БНХАУ, ОХУ-ын төрийн тэргүүн нарын уулзалт



## Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх БНХАУ-ын дарга Ши Жиньпинтэй уулзав



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БЭЭЖИН ХОТНОО БОЛСОН "БҮС БА ЗАМ" ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ДЭЭД ТҮВШНИЙ ГУРАВ ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ҮЕЭР БНХАУ-ЫН ДАРГА ШИ ЖИНЬПИНТЭЙ УУЛЗАВ.


Монгол, Хятадын харилцаа нь гадаад бодлогын тэргүүлэх чиглэл гэдгийг талууд дахин нотолж, бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хоёр улс болон ард иргэдийн сонгосон хөгжлийн замыг харилцан хүндэтгэж, язгуур эрх ашиг, чухалчлан үзэж буй асуудлаар харилцан биеэ дэмжиж, харилцаа, хамтын ажиллагаа өргөжин хөгжиж буйг санал нэгтгэж тэмдэглэв.

Цаашид дээд, өндөр түвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, хөгжлийн стратегийг харилцан уялдуулах, худалдааны хэмжээг ойрын хугацаанд 20 тэрбум ам.долларт хүргэх, худалдааны бүтцийг төрөлжүүлэх, хилийн боомтыг харилцан холбох, харилцаа, хамтын ажиллагааны эрх зүйн үндсийг бэхжүүлэх, дэд

бүтцийн томоохон төслүүдийн явцыг түргэтгэх, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах чиглэлээр хамтрах, байгаль орчин, эрүүл мэнд, боловсрол, шинжлэх ухаан, инновацын салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг чиглэлд нягт хамтран ажиллахаар тохиролцов.

Хоёр улс НҮБ болон бусад олон улсын байгууллагын хүрээнд хамтран ажиллаж ирсэн бөгөөд олон улсын тавцан дахь харилцан бие биеэ дэмждэг уламжлалт хамтын ажиллагааг өргөжүүлэхийн төлөө байгаагаар илэрхийлэв. Талууд уулзалтын үеэр олон улсын харилцааны асуудлаар санал солилцлоо.

## Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путинтэй уулзав



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БЭЭЖИН ХОТНОО БОЛСОН "БҮС БА ЗАМ" ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ДЭЭД ТҮВШНИЙ ГУРАВ ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ҮЕЭР ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ В.В.ПУТИНТЭЙ УУЛЗАВ.

Ерөнхийлөгч У.Хүрэлсүх хоёр улсын Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг улам гүнзгийрүүлэх, шинэ агуулгаар баяжуулах зорилтын хүрээнд худалдааны татварыг бууруулах, дэд бүтэц, эрчим хүчний салбарт бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөрүүдийг хамтран хэрэгжүүлэх нь чухал болохыг онцлов.

Монгол Улсаас ОХУ-д нийлүүлж буй мах, махан бүтээгдэхүүн, ноос ноолуур, арьс шир зэрэг хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүнд ноогдуулж буй татварыг бууруулах асуудлыг ойрын өдрүүдэд

Улаанбаатар хотноо болох Засгийн газар хоорондын комиссын ээлжит хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэхээр Ерөнхийлөгч нар тохиров.

Төрийн тэргүүн нар Монгол, Оросын хамтын ажиллагааны бэлгэ тэмдэг болсон "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн шинэчлэл хийх, Монгол Улсын баруун болон зүүн босоо тэнхлэгийн төмөр замын бүтээн байгуулалтад хамтран ажиллах талаар санал солилцов.



ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан - 2024

# ШХАБ-ын гишүүн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлнэ



2024.7.3 - 4

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН АСТАНА ХОТНОО 2024 ОНЫ 7 ДУГААР САРЫН 3-4-НИЙ ӨДРҮҮДЭД БОЛСОН ШХАБ-ЫН ГИШҮҮН ОРНУУДЫН ТӨРИЙН ТЭРГҮҮН НАРЫН ЗӨВЛӨЛИЙН ӨРГӨТГӨСӨН ХУРАЛДААНД АЖИГЛАГЧААР ОРОЛЦОЖ, ҮГ ХЭЛЛЭЭ.

Тэрбээр ШХАБ-ын ажиглагч улсын хувьд тус байгууллагын гишүүн, ажиглагч, яриа хэлэлцээний түнш орнуудтай хоёр талт болон олон талт форматын хүрээнд дээд, өндөр түвшний харилцан айлчлал, яриа хэлэлцээг тасралтгүй хийж ирснийг тодотгов. Цаашид ч ШХАБ-ын оролцогч нийт улс оронтой худалдаа, хөрөнгө оруулалт,


хүнс, хөдөө аж ахуй, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэржилт, тээвэр ложистик, боомтын дэд бүтэц, байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлал, мэдээллийн технологи болон хүмүүнлэгийн салбарт харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхийг зорьж байгааг тэмдэглэлээ.



ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путиний хамт




Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаевын хамт



НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутеррешийн хамт



Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч Рэжэл Тайип Эрдоаны хамт



Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Н.Жапаровын хамт

Монгол Улс ШХАБ-ыг олон талт хамтын ажиллагаанд оролцох чухал суваг хэмээн үзэж, 2004 онд ажиглагчийн статустай болсноос хойш тус байгууллагын дээд түвшний уулзалт болох Төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд тогтмол оролцож ирсэн юм.



## ГАДААД УЛСЫН ТӨРИЙН ТЭРГҮҮН НАРЫН МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЙЛЧЛАЛ

Монгол Улсын гадаад бодлогын зорилго нь дэлхийн улсуудтай найрсаг харилцаатай байж, улс төр, эдийн засгийн болон бусад салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын хамтын нийгэмлэгт байр сууриа бэхжүүлэх, хөгжил дэвшлийг хурдасгах замаар улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататгах явдал мөн. Монгол Улсын аюулгүй байдал, үндэсний язгуур ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн хүрээнд улс төр-дипломатын аргаар хангах нь гадаад бодлогын тэргүүлэх зорилт мөн.

*Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалаас*

# 3



Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал



## Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч Анджей Дуда



2023.4.24-26

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ УХУРЭЛСҮХИЙН УРИЛГААР БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ АНДЖЕЙ ДУДА 2023 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 24-26-НЫ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.

Айлчлалын хүрээнд олон улсын авто тээвэр, геологи, мал эмнэлэг, архив зэрэг салбарт хамтран ажиллах тухай баримт бичигт гарын үсэг зурж, Улаанбаатар хотноо БНПУ Элчин сайдын яамаа албан ёсоор нээлээ. Талууд "Хүнсний хангамж, аюулгүй байдал", "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хамтран ажиллаж, харилцан ашигтай томоохон төсөл хөтөлбөрүүдийг хөдөө аж ахуй, байгаль орчин зэрэг салбарт хэрэгжүүлэхээр санал нэгдэв. Мөн хоёр улс НҮБ болон олон улсын бусад байгууллагын хүрээнд хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэхээ нотоллоо. Хоёр улс төрийн тэргүүний түвшинд 5-10 жилийн давтамжтай харилцан айлчлал хийсэн бөгөөд өмнөх айлчлалаас хойш 10 жилийн дараа Ерөнхийлөгч Анджей Дуда айлчилсан нь хоёр орны харилцааны түүхэнд тодоор бичигдэв.





Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал

## Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макрон

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ЭММАНУЭЛ МАКРОН 2023 ОНЫ 5 ДУГААР САРЫН 21-22-НЫ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.



2023.5.21-22




Энэ үеэр харилцаа, хамтын ажиллагааг шат ахиулж, Стратегийн түншлэлд хүргэх, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрийг харилцан ашигтай хамтран хэрэгжүүлэх, ногоон эрчим хүч, зам тээвэр, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, соёл, боловсрол, хүмүүнлэг зэрэг салбарын харилцааг тэлэх талаар санал солилцов.



Түүнчлэн "Хүнсний хангамж, аюулгүй байдал", "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Ерөнхийлөгчийн илгээлт-2100" хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллах талаар ярилцав. Франц Улсын Ерөнхийлөгч Эммануэл Макроны Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын хүрээнд

талууд Хамтарсан тунхаглал гаргав. Энэхүү тунхаглал нь хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг шинэ шатанд гаргасан түүхэн ач холбогдолтой баримт бичиг болсныг Төрийн тэргүүн нар тэмдэглэв.



Энэ нь Франц Улсаас Төрийн тэргүүний түвшинд хийсэн анхны түүхэн айлчлал болсон юм.



Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал


## Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч Садыр Нургожоевич Жапаров



2023.7.9-11



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ С.Н.ЖАПАРОВ 2023 ОНЫ 7 ДУГААР САРЫН 9-11-НИЙ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.



Ерөнхийлөгч нар "Найрсаг харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын Хамтарсан тунхаглал"-д гарын үсэг зурав. Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг Киргиз Улсын "Ногоон өв" санаачилгатай уялдуулах, Эрдэнэт хотод "Монгол, Киргизийн найрамдлын төгөл" байгуулах, Киргизийн жимс, жимсгэний модны суулгацыг Монголд нутагшуулах, хүрээлэн буй орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх чиглэлээр идэвхтэй хамтрахаар тогтов. Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Н.Жапаров Үндэсний их баяр наадмын нээлт зэрэг ёслолд хүндэт зочноор оролцсоны зэрэгцээ тус улс Улаанбаатар хотноо Элчин сайдын яамаа нээв.



Бүгд Найрамдах Киргиз Улсын Ерөнхийлөгч С.Н.Жапаров "Эрдэнэт" үйлдвэртэй танилцав.



2023.8.31-9.4



Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал

## Гэгээн Ширээт Улсын Төрийн тэргүүн Пап Францис

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР ГЭГЭЭН ШИРЭЭТ УЛСЫН ТӨРИЙН ТЭРГҮҮН ПАП ФРАНЦИС 2023 ОНЫ 8 ДУГААР САРЫН 31-НЭЭС 9 ДҮГЭЭР САРЫН 4-НИЙ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД АНХ УДАА ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.

Энэхүү түүхэн айлчлал нь Чингис хааны мэндэлсний 860 жил, Монгол Улс, Гэгээн Ширээт Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 30 жилийн ойн хүрээнд болсноороо ач холбогдолтой. Түүнчлэн Европын анхны элч төлөөлөгч, санваартан Пано Карпини Монголд зорчсоноос 777 жилийн дараа тус улсын төрийн тэргүүн Пап Францис Их Монгол Улсын гал голомтод айлчилсан нь цаг тооны хувьд онцлог үйл явдал болов.

Монгол Улсад хийсэн энэхүү төрийн айлчлал нь манай улсын олон тулгуурт, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого, хоёр орны харилцааны түүхэнд нэгэн шинэ хуудсыг нээж, манай хоёр орны цаашдын найрсаг харилцаа, хамтын ажиллагаанд түүхэн чухал үүрэг гүйцэтгэв.



Гүюг хааны захидлын албан ёсны хуулбарыг Пап Францис Монгол Улсад бэлэглэв.



## Ерөнхийлөгч У.Хүрэлсүх ИБУИНХУ-ын Цог Жавхлант Хаан III Чарльзыг хаан сэнтийд залах ёслолд оролцов



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ГЭРГИЙ Л.БОЛОРЦЭЦЭГИЙН ХАМТ ЛОНДОН ХОТЫН ВЭСТМИНС-ТЕРИЙН СҮМД ИХ БРИТАНИ, УМАРД ИРЛАНДЫН НЭГДСЭН ХААНТ УЛСЫН ЦОГ ЖАВХЛАНТ ХААН III ЧАРЛЬЗЫГ ХААН СЭНТИЙД ЗАЛАХ ТӨРИЙН ЁСЛОЛД ОРОЛЦОВ. МЯНГА ГАРУЙ ЖИЛИЙН ӨНӨ ЭРТНИЙ ТҮҮХТ ӨВӨРМӨЦ ЗАН ҮЙЛ БҮХИЙ ЁСЛОЛД МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ТЭРГҮҮН АНХ УДАА ОРОЛЦСОН ЮМ.



2023.5.6



# Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Колизеум театрт зочлов



ИБУИНХУ-ын Цог Жавхлант Хаан III Чарльзыг хаан сэнтийд залах төрийн ёслолд оролцох үеэр



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх "Илгээлт-2100" хөтөлбөрийн хүрээнд ИБУИНХУ-д суралцаж буй оюутнуудтай уулзав.

# "Монгол хаан" жүжгийг Лондон хотын Колизеум театрт тоглов



Монгол Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд Ардын уран зохиолч, Төрийн шагналт, зохиолч, яруу найрагч Б.Лхагвасүрэнгийн "Тамгагүй төр" жүжиг Лондон хотын Колизеум театрт "Монгол хаан" нэрээр 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 12 дугаар сарын 2-ны өдрүүдэд олны хүртээл болов.

Уг жүжиг Британийн төдийгүй олон улсын үзэгчдэд хүрсэн нь Монгол Улсын соёлын томоохон сурталчилгаа болсны сацуу Монголын театрын урлагийн шинэ эринийг дэлхийн тавцанд тунхагласан үйл явдал болсон юм. Түүнчлэн Монгол, Британийн уран бүтээлчид "Монгол хаан" жүжгийн зохиолоос сэдэвлэсэн график комик номыг хамтран бүтээж, номын нээлтийг 2023 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр Колизеум театрт хийв.





Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал



2024.2.7-8

# Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэр

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР ХОЛ-БООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ФРАНК-ВАЛЬТЕР ШТАЙНМАЙЭР 2024 ОНЫ 2 ДУГААР САРЫН 7-8-НЫ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.

*Хоёр орны харилцааны түвшинг ахиулж "Стратегийн түншлэл"-ийн тухай Хамтарсан тунхаглалд гарын үсэг зурав. Ингэснээр гуравдагч хөрш ХБНГУ нь Европын орнуудаас стратегийн түншлэл байгуулсан анхны улс болов.*


Талууд эдийн засгийг төрөлжүүлэх, хууль эрх зүй, шүүхийн чадавхыг сайжруулах, тогтвортой эрчим хүч, соёл, боловсрол, шинжлэх ухаан, байгаль орчин, археологийн салбарт хамтран ажиллах тухай зэрэг баримт бичигт гарын үсэг зурав.

Мөн олон улсын харилцааны тулгамдсан асуудлаар санал солилцож, дэлхий нийтийн энх тайван, тогтвортой хөгжлийн төлөө хамтын хүчин чармайлт гаргахаа илэрхийлэв.



# Герман – Монгол толь бичгийн судлал дахь "Шинэ олдвор"

Баруун Германд дорно дахины салбарыг, тэр дундаа монгол судлалын төвийг байгуулсан нэрт эрдэмтэн нь В.Хайссиг профессор юм. Энэ агуу эрдэмтэн монгол судлалаар зөвхөн барууны орнууд төдийгүй, дэлхийд хэвлэгдсэн бүтээлүүдийг цуглуулж маш том номын сан байгуулах зорилготой ажилласан байдаг. Зорилгодоо ч хүрч, монгол судлалын номын санг байгуулсан юм.



Чухам түүний ачаар их зохиолч Д.Нацагдорж хорин хэдхэн насандаа Германд хийсэн толь бичгийн анхны гар бичмэл тус улсад хадгалагдаж үлдсэнийг ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал Ж.Бат-Ирээдүй 2017 онд тун санамсаргүй илрүүлсэн байдаг. Тэрбээр Боннын их сургуульд 2015–2017 онд гурван он дамнан Монгол, төвөд хэлний тэнхимд зочин профессороор ажиллаж байсан тухайгаа, "Миний ажиллаж байсан тэр тэнхим Боннын их сургуулийн хамгийн гоё байшинд байрладаг байв. Байшинг их засварт оруулахаар болж, бид тэр баялаг номын санг нүүлгэхээр бүх номыг нь



Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал Ж.Бат-Ирээдүй

хурааж, хайрцаглаж байтал тус номын сангийн ажилтан Карл надад "Герман-Монгол толь" бичгийн хоёр дэвтэр гар бичмэл эхийг үзүүлсэн.

Тэдгээр дэвтэр нь 1926–1927 онд Лайпцигт байхдаа Д.Нацагдоржийн зохиосон толь бичгийн цорын ганц эх хувь байлаа. Тэрхүү эх дээрээ монгол судлалын алдартай эрдэмтэн Эрих Хэнишийн удирдлага дор 1927 онд зохиосон гэдгээ их зохиолч өөрийн гараар, маш тодорхой бичсэн байв" хэмээн Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлагт өгсөн ярилцлагадаа дурдсан нь бий.

Монгол, Германы соёлын харилцааны баялаг түүхийн нэгэн гэрч болсон уг алдарт толь бичиг нь хоёр дэвтэр, нийт 302 хуудастай. Герман-Монгол хэлний хамгийн анхны хоёр хэлний толь бичиг төдийгүй герман үгийн монгол оноолтыг их зохиолч өөрөө монгол бичгээр бичсэнээрээ нэн онцлог юм.

Нэрт эрдэмтэн Эрих Хэнишийн удирдлагаар Германд монгол судлал эрчимтэй хөгжсөн бөгөөд түүний судалгааны ажил их бүтэмжтэй, хурдтай өрнөсөн он жилүүдэд Д.Нацагдоржтой багш, шавийн барилдлагатай байсан он жилүүд хамаарагддаг байна.



## Монгол охины нэрээр нэрлэгдсэн герман шоколад



Дэлхийн ноён оргил, Гималайн нурууг даван нисдэг хүчирхэг жигүүртнээс ч өндөрт "нисэх" ийм л хариуцлага, тийм л мөрөөдлийг өвөрлөн, 1926 онд 41 залуу өрнийг зорьсон нь юутай бахтай, юутай гэгээн зам байсныг их зохиолч Д.Нацагдорж "Алс газар сурахаар явагч" шүлэгтээ өгүүлсэн байдаг билээ.

Ийнхүү өрнийн өндөр хөгжилтэй орноос ганзага дүүрэн ирсэн тэдгээр 40 сурагч ар араасаа мянга мянган залуусыг сурч мэдэхийн гэгээн замд хөтөлсөн анхдагчид байсан төдийгүй Монгол, Герман хоёр орны ард түмний бие биеэ ойлгон нөхөрлөх, найрсаг дотно харилцааны үндэс суурийг бахархалтай сайхан тавьж өгсөн шилдэг залуус байлаа.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсаа тунхаглаад удаагүй байсан тухайн үед цаашид улс орноо хэрхэн хөгжүүлэх, ямар замаар аль зүгт хөдлөхөө шийдэх асуудалтай тулгарсан төр Засгийн газраас өндөр хөгжилтэй хэд хэдэн орныг сонгон авч, 10 хүн тутмын

хэд нь бичиг үсэгтэй байгааг нь хүртэл харьцуулан судалжээ. Тэр судалгааны үр дүнд Герман, Франц улс хамгийн өндөр боловсролтой болохыг олж таньсан байна.

Маш нарийн бодлого, төлөвлөгөөгөөр хүч хөрөнгө зарцуулж бэлдэж байсан тэдгээр хүүхдийг герман соёл, төлөвшилд ойр байлгах үүднээс Германы тал дотуур байранд биш, айлд байлгахыг чухалчилж байв. Энэ тухай Д.Сурмаажавын охин Н.Баясгалан телевизийн нэвтрүүлэгт оролцохдоо, "Миний ээж чинээлэг айлд амьдарч байсан гэдэг. Ээжтэй маань нас бие чацуу нэг охинтой байсан юм билээ. Ээжийг маань охинтойгоо яг адилхан хувцасладаг байсан гэсэн. Харин Г.Хаалаа нь шоколадны үйлдвэрийн эзнийд суусан юм билээ. Тэр айл нэг хүүтэй, тэр хүү нь түүнд сэтгэл алдарч, төрсөн өдрөөр нь "Хаалаа" нэртэй шоколад гаргасан гэж ээж маань ярьдаг байсан" хэмээн дурсжээ.




Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал

# Бүгд Найрамдах Беларусь Улсын Ерөнхийлөгч Александр Григорьевич Лукашенко

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ А.Г.ЛУКАШЕНКО 2024 ОНЫ 6 ДУГААР САРЫН 1-4-НИЙ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.

Айлчлалын үеэр хоёр улсын төрийн тэргүүн нар "Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Беларусь Улс хоорондын гэрээ"-нд гарын үсэг зурав. Тус гэрээ уламжлалт найрсаг харилцааны үндсийг тодорхойлсон чухал баримт бичиг бөгөөд хамтын ажиллагаа шинэ шатанд гарч, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл болон бусад салбар дахь харилцаа өргөжин хөгжих ач холбогдолтой юм.

Мөн 2024-2026 онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны замын зураглал, Засгийн газар хоорондын хэлэлцээр, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, хууль, хөдөө аж ахуй, боловсрол, шинжлэх ухаан, байгаль орчин, аялал




2024.6.1-4



жуулчлал, онцгой байдал, оюуны өмч зэрэг салбарт хамтрах тухай баримт бичигт гарын үсэг зурав.

Айлчлал нь хоёр улсын хооронд

дипломат харилцаа тогтоосноос хойш Беларусь Улсын төрийн тэргүүний түвшинд манай улсад хийсэн анхны айлчлал болов.



Хүүхдийн урлан бүтээх төвийн багш Б.Туяа:

## Беларусийн сүрлэн урлалыг 5000 монгол хүүхэд эзэмшсэн

Б.Цэрэндорж багш маань анх Беларусийн Чечерскийн районд хуучнаар ТМС, одоогийн техник мэргэжлийн сургуульд сурч байсан монгол сурагчдыг хариуцан ажиллаж байсан юм билээ.

Тэгж явахдаа сүрлэн урлалыг сонирхож, сурсан гэдэг. Тэр үеэс сурагчдадаа сүрлэн урлал зааж, эх орондоо ирээд тэнд төгссөн шавь нарынхаа хамт Монголын Хүүхдийн урлан бүтээх төвд дугуйлан нээсэн. Хүүхдийн урлан бүтээх төвийг анх 1988 онд байгуулахад, манайх сүрлэн наамал, сүрлэн сүлжмэл гэсэн хоёр ангитай байсан юм билээ. Тухайн үед сүрлэн урлалын дугуйлан зонхилж байгаад, дараа нь зургийн анги нэмэгдсэн. Тэгж явсаар одоо хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлдэг, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх



олон дугуйлантай болоод байна. Хүүхдүүдэд бүтээлч сэтгэхүй суулгахад ихээхэн ач холбогдолтой

гэдэг үүднээс л багш маань сүрлэн урлалыг Монголдоо нэвтрүүлсэн гэж би боддог.



2024.6.11-12



# Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгч Тонглун Сисүлит

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ЛАОС АРД УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ТОНГЛУН СИСҮЛИТ 2024 ОНЫ 6 ДУГААР САРЫН 11-12-НЫ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.

Айлчлалын үеэр Төрийн албаны шинэтгэл, эрүүл мэнд, анагаах ухааны салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээр тохирч, баримт бичгүүдэд гарын үсэг зурав.

Мөн Монгол Улсаас БНАЛАУ-д экспортлох үхэр, адуу, хонь, ямааны махны Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний загвар, нөхцөл, шаардлагаа харилцан тохиролцож баталгаажууллаа. Ингэснээр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2023 онд Лаос улсад хийсэн төрийн айлчлалын үеэр ярьж тохирсон санал санаачилга бодит ажил хэрэг болов.



## Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал

Энэхүү айлчлал нь БНАЛАУ-ын төрийн тэргүүний түвшинд 2007 оноос хойш буюу 17 жилийн дараа, Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн 2023 онд Лаос улсад хийсэн төрийн айлчлалын хариу айлчлал юм.



Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Л.Галбадрах:

### Монголоос бэлэглэсэн 1000 хонийг Лаост нутагшуулахад оролцсон

Лаос нутагт олон сайхан дурсамжтай мөч тохиолдож байлаа. Лаосчууд маш найрсаг, тайван, энгийн, монголчууд бидэнд нэн элгэмсэг ханддаг нь тэнд ажиллах, тэдэнтэй ойлголцоход хялбар байсан.

Монголын Засгийн газраас бэлэглэсэн 1000 гаруй хонийг тээвэрлэн аваачиж, Лаосын харьцангуй сэрүүн, уулархаг хойд нутагт нутагшуулах ажилд оролцсон нь тод дурсамж үлдээжээ.

Лаост ажиллахаар очсон эмч нарыг онгоцноос буухад Монгол Улсын анагаахын их сургуулийн ромбыг энгэртээ зүүсэн лаос эмч нар маш хүндэтгэлтэй угсанд сэтгэл нь ихэд хөдөлснөө Н.Алтанцэцэг эмч бичсэн байдаг



л даа. Тоссон хүмүүс нь Монголд төгссөн лаос эмч нар байсан юм билээ. Энэ мэт олон сайхан дурсамжийг Лаост Элчин сайдаар

сууж байсан эрхмүүд болон тэнд сурч, ажиллаж, амьдарч байсан хүмүүсийн дурсамж яриаг уншиж, сонсож байв.



Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал



2024.7.8-15

# Бутаны Хаант Улсын Цог Жавхлант Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчук

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР БУТАНЫ ХААНТ УЛСЫН ЦОГ ЖАВХЛАНТ ХААН ЖИГМЭ ГЭСЭР НАМЖИЛ ВАНЧУК 2024 ОНЫ 7 ДУГААР САРЫН 8-15-НЫ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.



Айлчлалын үеэр Монгол, Бутаны хамтарсан мэдэгдэл болон ХАА, соёл, боловсрол, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх баримт бичгүүдэд гарын үсэг зурав.

Төрийн тэргүүн нар уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх, байгаль орчноо хамгаалах дэлхий нийтийн хүчин чармайлтад хувь нэмрээ оруулах чиглэлээр хамтарч, "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн болон "Зуун сая жимсний мод" тарих санаачилгын хүрээнд хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэхээр боллоо.

Мөн иргэд хоорондын солилцоог өргөжүүлэх зорилгоор "Go Mongolia" үндэсний брэндийг "Bhutan Believe" үндэсний брэндтэй уялдуулахаар тогтов.



Тус айлчлал нь Бутаны Хаант Улсын Цог Жавхлант Хааны Монгол Улсад хийсэн анхны төрийн айлчлал болов. Хоёр улс 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр дипломат харилцаа тогтоосон юм.





Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал

# Швейцарын Холбооны Улсын Ерөнхийлөгч Виола Амхерд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР ШВЕЙЦАРЫН ХОЛ-  
БООНЫ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ВИОЛА АМХЕРД 2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 2-4-  
НИЙ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.



2024.8.2-4

Энэхүү төрийн айлчлал нь харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд томоохон түлхэц болсныг талууд онцлов. Айлчлалаар "Монгол, Швейцарын хамтарсан тунхаглал", "Ардчилсан засаглалын асуудлаарх Харилцан ойлголцлын санамж бичиг"-т гарын үсэг зурснаа зарлалаа.

Эдгээр баримт бичиг нь манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны цаашдын чиглэлийг тодорхойлж, ардчилсан засаглалыг улам бэхжүүлэхэд чухал хувь нэмэр

оруулах юм. Уг айлчлал нь энэ онд тохиож буй Монгол Улс, Швейцарын Холбооны Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд хэрэгжсэн бөгөөд Швейцарын талаас төрийн тэргүүний түвшинд хийсэн анхны төрийн айлчлалд тооцогдож байна.

Монгол Улс, Швейцарын Холбооны Улсын хооронд 1964 оны 5 дугаар сарын 22-ны өдөр дипломат харилцаа тогтоожээ.



Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал

## Бүгд Найрамдах Словени Улсын Ерөнхийлөгч Наташа Пирц Мусар



2024.8.20-23

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ УХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР БҮГД НАЙРАМДАХ СЛОВЕНИ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ НАТАША ПИРЦ МУСАР 2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 20-21-НИЙ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙЖ, 22-23-НЫ ӨДРҮҮДЭД УЛААНБААТАР ХОТНОО БОЛСОН ДЭЛХИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТАД ХҮНДЭТ ЗОЧНООР ОРОЛЦОВ.

Хоёр улсын төрийн тэргүүн нар албан ёсны хэлэлцээ хийж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, даян дэлхийн Тогтвортой хөгжлийн зорилтууд тухайлбал, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах зэрэг чиглэлд хамтарч ажиллахаар ярилцаж, олон улсын харилцааны зарим асуудлаар санал солилцов.

Түүнчлэн Монгол-Словенийн Хамтарсан тунхаглал,

хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг тээвэр, аялал жуулчлал, ой зэрэг салбарт гүнзгийрүүлэхэд чиглэсэн баримт бичигт гарын үсэг зурав. Монгол Улс, Бүгд Найрамдах Словени Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 30 жилийн ой 2023 онд тохиосон юм. Энэхүү тэмдэглэлт ойн хүрээнд хэрэгжсэн төрийн айлчлал нь Словени Улсын Ерөнхийлөгчийн түвшинд манай улсад хийсэн анхны айлчлал болов.





Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал

## Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Владимир Владимирович Путин

ХАЛХ ГОЛЫН БАЙЛДААНЫ 85 ЖИЛИЙН ОЙ, МОНГОЛ, ОРОСЫН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН "УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ" НИЙГЭМЛЭГ ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 75 ЖИЛИЙН ОЙ, НАЙРСАГ ХАРИЛЦАА, ИЖ БҮРЭН СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ МОНГОЛ УЛС, ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС ХООРОНД ГЭРЭЭ БАЙГУУЛАГДСАНЫ ТАВАН ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧ В.В.ПУТИН 2024 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 2-3-НЫ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ХИЙВ.



Айлчлалаар хоёр орны найрсаг харилцаа, харилцан ашигтай хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулав. Ялангуяа түлш, эрчим хүч, зам тээвэр, байгаль орчин, соёл, боловсрол, эрүүл мэнд, хүмүүнлэгийн салбарын хамтын ажиллагааг урагшлуулахад түлхэц болов. ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин БНМАУ-ын баатар, ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар маршал Г.К.Жуковын хөшөөнд хүндэтгэл илэрхийлж, цэцэг өргөсний зэрэгцээ Г.В.Плехановын нэрэмжит сургуульд зочлов. Хоёр улс 1921 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр дипломат харилцаа тогтоож, дараа жил нь Элчин сайдын яамаа Улаанбаатар, Москва хотноо харилцан нээсэн түүхтэй.



Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал

## Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ерөнхийлөгч То Лам



2024.9.30-10.1

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ БӨГӨӨД КОММУНИСТ НАМЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА ТО ЛАМ 2024 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 30-НААС 10 ДУГААР САРЫН 1-НИЙ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.




Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2023 онд Вьетнам Улсад хийсэн төрийн айлчлалын хариу айлчлал бөгөөд хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд хэрэгжсэнээрээ онцлог юм.

Айлчлалын хүрээнд хоёр улсын төрийн тэргүүн ганцаарчилсан уулзалт болон албан ёсны хэлэлцээ хийж, улс хооронд болон олон улс, бүс нутгийн тавцан дахь хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

Монгол Улс Зүүн өмнөд Азийн улс орнуудаас хамгийн түрүүнд Вьетнам Улстай "Иж бүрэн түншлэл"-ийн харилцаа тогтоож буйгаа тунхаглан зарлаж, харилцаа, хамтын ажиллагааны баримт бичгүүдэд гарын үсэг зурлаа.

Хоёр улс харилцан ашигтай, бие биеэ нөхсөн харилцаа, хамтын ажиллагааг бүхий л салбарт өргөжүүлэн хөгжүүлэхийн төлөө буйгаа нотоллоо.

Түүнчлэн манай хоёр орны хамтын ажиллагааны бэлгэ тэмдэг болон хөгжиж буй Хөдөлгөөнт цагдаагийн дэргэдэх Морьт цагдаагийн хороонд нэр төртэй алба хашсан монгол морьдыг нутаг буцаахаар болов.



Мөн үеэр Ерөнхийлөгч То Лам Хо Чи Минийн нэрэмжит улсын тэргүүний 14 дүгээр сургуульд зочиллоо.

### Вьетнамд алба хааж буй монгол морьд

Ээрэм талын салхинаас өөр манах эзэнгүй эрх чөлөөтэй бэлчиж, хэрэгцээтэй цагт хэнийг ч унаа залгуулж чадах жижигхэн биедээ баймгүй гайхалтай тэсвэртэй, хурдтай адуу бол монгол адуу. Өндөр өндөр уулстай, өргөн далайн хөвөөнд ч энэ адуу өөрийн мөн чанарыг гайхуулан алба хааж байна.

Тэртээ мянга мянган км-ийн цаана очиж алба хаах болсон түүх 2019 оноос эхтэй. Тус онд Вьетнамын Нийгмийн аюулгүй байдлын яамны сайдаар ажиллаж байсан То Лам Хууль зүй, дотоод хэргийн яаманд монгол морьдыг Вьетнамд аваачих тухай саналаа илэрхийлж байжээ. Дараа жил нь албан ёсны гэрээ хийсний дагуу 4 азарга, 20 гүү, 81 морь, нийт 105 адуу Вьетнамыг зорьсон юм.

Өнөөдөр эдгээр адуу 140 толгой болжээ. Энэ цагаас эхлэн монгол морьд Вьетнамын Хөдөлгөөнт цагдаагийн командлалын Морьт цэр-



гийн хорооны алба хаагчидтай цуг эрэн хайх, аврах, ялангуяа машин техник ашиглах боломжгүй хилийн бүс, уулархаг нутагт хүчин зүтгэж, аюулгүй байдлыг сахиулахаар ажиллаж байна. Тус хорооны алба хаагчид монгол морьдоо унан, Вьетнам улсад зохион байгуулсан

Зүүн өмнөд Азийн спортын XXXI их наадмын нээлт зэрэг томоохон үйл ажиллагаанд үүрэг гүйцэтгэжээ.

Тэртээ холын улсад тэнгэрийн доор монгол морьд янцгааж, энхийн манаанд үүрэг гүйцэтгэж явна.



2024.10.28-29



## Бүгд Найрамдах Казахстан Улсын Ерөнхийлөгч Касым-Жомарт Токаев

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХИЙН УРИЛГААР БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ КАСЫМ-ЖОМАРТ КЕМЕЛЕВИЧ ТОКАЕВ 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 28-29-НИЙ ӨДРҮҮДЭД МОНГОЛ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.




### Гадаад улсын Төрийн тэргүүн нарын Монгол Улсад хэрэгжүүлсэн айлчлал



Энэхүү айлчлалаар Монгол, Казахстаны харилцаа, хамтын ажиллагааг шат ахиулж, "Стратегийн түншлэл"-ийн түвшинд хүргэн хөгжүүлэх түүхэн шийдвэрийг гаргав. Ингэснээр Казахстан улс Төв Азийн бүс нутаг дахь манай улсын анхны "Стратегийн түнш" орон болов. Түүнчлэн Монгол, Казахстаны харилцааны эрх зүйн үндсийг бэхжүүлж, тээвэр логистик, хөдөө аж ахуй, мал эмнэлэг, мэдээллийн технологи, соёл, аялал жуулчлал зэрэг салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх Засгийн газар

болон байгууллага хоорондын баримт бичгийг байгуулав. Ерөнхийлөгч К.Токаев төрийн айлчлалынхаа үеэр "Чингис хаан" үндэсний музейд зочиллоо. Ерөнхийлөгч К.Токаевын энэ удаагийн төрийн айлчлал Казахстан улсын төрийн тэргүүний түвшинд 2008 онд хийсэн айлчлалаас хойш 16 жилийн дараа болов. Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс 1992 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр дипломат харилцаа тогтоосон юм.



# МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ТЭРГҮҮНИЙ ГАДААД УЛСАД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЙЛЧЛАЛ

Монгол Улс бусад улстай харилцахдаа бие биеийн тусгаар тогтнол, бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, өөртөө засан тогтнох бүрэн эрхийг харилцан хүндэтгэх, дотоод хэрэгт үл оролцох, маргаантай асуудлыг эв зүйгээр шийдвэрлэх, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллах зэрэг НҮБ-ын Дүрэмд тодорхойлж, нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын эрх зүйн зарчим, хэм хэмжээ, түүнчлэн хоёр талын харилцааны үндсэн баримт бичгүүдэд заасан бусад зарчмыг удирдлага болгоно.

*Монгол Улсын Гадаад бодлогын  
үзэл баримтлалаас*





Монгол Улсын Төрийн тэргүүний гадаад улсад хэрэгжүүлсэн айлчлал

## Бүгд Найрамдах Франц Улсад төрийн айлчлал хийв

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ 2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 10-14-НИЙ ӨДРҮҮДЭД БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ. ТӨРИЙН АЙЛЧЛАЛЫН ХҮРЭЭНД ХОЁР УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАРИМТ БИЧИГТ ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА.

Үүнд:

1. ОБЕГ-ын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төслийн санхүүжилт олгох тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээр,
2. ОБЕГ-т гал унтраах тусгай зориулалтын машин нийлүүлэх төслийн санхүүжилт олгох тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын санхүүгийн хэлэлцээр,
3. Монгол Улсын Засгийн газар болон "Орано майнинг" компанийн хооронд байгуулах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөл боловсруулах ажлын хэсгийн хэлэлцээний протокол,
4. Монгол Улсын Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон БНФУ-ын "Thales Alenia Space" компанийн хоорондын Харилцан ойлголцлын тухай санамж бичиг,
5. Геологийн шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тухай чиглэлээр хамтран ажиллах тухай Францын Геологи, уул уурхайн судалгааны товчоо болон Монголын Үндэсний геологийн алба хоорондын Харилцан ойлголцлын санамж бичиг,
6. Бүгд Найрамдах Франц Улсын Геологи уул уурхайн судалгааны товчоо, Францын геофизикийн ерөнхий компани болон Монголын үндэсний геологийн алба хоорондын эрмэлзлийн захидал.



2023.10.10-14



2023.10.10-11

## Морин хуурын чуулга Версалийн ордонд тоглов

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн Бүгд Найрамдах Франц Улсад хийсэн төрийн айлчлалын хүрээнд Монгол Улсын Соёлын элч Морин хуурын чуулга 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Версалийн ордны Хааны дуурийн театрт анх удаа тоглов.

Морин хуурын чуулга тус театрын тайзнаа үндэсний, ардын болон сонгодог төрлийн 15 бүтээлийг толилуулсан юм.



## "Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь" үзэсгэлэнг нээв



"Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь" үзэсгэлэнгийн нээлтийн ёслол 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Нант хотын түүхийн музейд боллоо.

Үзэсгэлэнд "Чингис хаан" үндэсний музей, Монголын үндэсний музей, Хархорум музей, ШУА-ийн Археологийн хүрээлэн, хувь цуглуулагчаас, мөн Францын Лувр, Сэвр, Азийн урлагийн Гимэй, Франц Улсын Ерөнхийлөгч асан Жак Ширакийн нэрэмжит Брэнли музей, Европын Берлин, Цюрих, Брюселийн зэрэг дэлхийд алдартай 20 гаруй музейгээс цуглуулсан 555 үзмэрийг дэлгэв.

Монголчуудын бахархал болсон баатарлаг өвөг дээдсийн түүх, хүн төрөлхтөнд үлдээсэн агуу их өв соёлыг БНФУ-ын Нант хотын Бретанийн гүнгийн шилтгээн-Нантын түүхийн музейд дэлгэн толилуулж, дэлхий нийтийн хүртээл болгож байгаад баяртай байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн хэлсэн үгээс

Монгол Улсын Төрийн тэргүүний гадаад улсад хэрэгжүүлсэн айлчлал

## Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсад төрийн айлчлал хийв

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ 2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 1-5-НЫ ӨДРҮҮ-ДЭД БҮГД НАЙРАМДАХ СОЦИАЛИСТ ВЬЕТНАМ УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.



2023.11.1-5

Төрийн тэргүүн нар Монгол, Вьетнамын Хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурав. Мөн хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны баримт бичигт гарын үсэг зурах ёслол боллоо. Үүнд:

1. Дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр,

2. Мэдээлэл солилцоо болон цагаачлалын менежментийн тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,


3. Үндэстэн дамнасан мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгтэй тэмцэх тухай Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,

4. Хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,

5. Стратеги судалгааны чиглэлээр хамтран ажиллах тухай Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Нийгмийн аюулгүй байдлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,

6. Цагаан будааны худалдааны тогтвортой нийлүүлэлтийн тухай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Аж үйлдвэр, худалдааны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,

7. Монгол Улсаас БНСВУ-д экспортлох ямаа, хонины махны "Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ" болон БНСВУ-аас Монгол Улсад экспортлох шувууны мах, махан бүтээгдэхүүний "Мал эмнэлгийн ариун цэврийн гэрчилгээ".






Монгол Улсын Төрийн тэргүүний гадаад улсад хэрэгжүүлсэн айлчлал


## Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад төрийн айлчлал хийв

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ 2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 5-7-НЫ ӨДРҮҮДЭД БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН ЛАОС АРД УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.



Төрийн айлчлалын хүрээнд хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны дараах баримт бичгийг байгуулав. Үүнд:

1. Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр,
2. Мал эмнэлэг, мал амьтны хорио цээрийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр,
3. Ургамал хамгаалал, хорио цээрийн тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр,
4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хооронд хамтран ажиллах санамж бичиг,



ран ажиллах тухай Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Мэдээлэл, соёл, аялал жуулчлалын яам хоорондын хэлэлцээр,

6. Байгалийн нөөц, байгаль орчныг хамгаалахад хамтран ажиллах тухай Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Байгалийн нөөц, байгаль орчны яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,

7. Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Соёлын яам, Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Мэдээлэл, соёл, аялал жуулчлалын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг.

чийн Тамгын газар хооронд хамтран ажиллах санамж бичиг,

5. Аялал жуулчлалын салбарт хамт-



2023.11.5-7



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Лаос Улсад суралцаж буй монгол оюутнуудтай уулзав.

Монгол Улсын Төрийн тэргүүний гадаад улсад хэрэгжүүлсэн айлчлал

## Бүгд Найрамдах Узбекистан Улсад төрийн айлчлал хийв



2024.6.23-26

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ БҮГД НАЙРАМДАХ УЗБЕКИСТАН УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ШАВКАТ МИРЗИЁЕВИЙН УРИЛГААР 2024 ОНЫ 6 ДУГААР САРЫН 23-26-НЫ ӨДРҮҮДЭД ТУС УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.



Төрийн тэргүүн нар "Худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг 2024-2026 онд хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр" байгуулсныг сайшааж, худалдааны эргэлтийг 10-20 дахин нэмэгдүүлэх, Монголоос Узбекистаны зах зээлд болон тус улсаар дамжуулан Төв Азийн бүс нутгийн бусад улс оронд ноос ноолуур, арьс шир, мах, махан бүтээгдэхүүн нийлүүлэх, Узбекистанаас жимс жимсгэнэ, хүнсний ногоо импортлох чиглэлд хамтран ажиллахаар тогтов.



"Монгол Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улс хоорондын харилцаа, хамтын ажиллагааны хамтарсан мэдэгдэл"-д Төрийн тэргүүн нар гарын үсэг зурлаа. Үүнд:


1. Монгол Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улс хооронд худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг хөгжүүлэх 2024-2026 оны хөтөлбөр,
2. Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр,
3. Олон улсын авто тээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр,
4. Агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр,
5. Мал эмнэлгийн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн

яам, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Хөдөө аж ахуйн яам хоорондын хэлэлцээр,

6. Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Бүгд Найрамдах Узбекистан Улсын Хөдөө аж ахуйн яам хоорондын хэлэлцээр,

7. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, соёл, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах тухай Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Ташкент хотын Хокимият хоорондын хэлэлцээр,

8. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, Узбекистаны Аж үйлдвэрийн танхим, МОНЦАМЭ агентлаг, Узбекистаны үндэсний мэдээллийн "УзА" агентлаг хоорондын хамтын ажиллагааны баримт бичиг.



Судлаач З.Мэнд:

### Узбекистанд Элчин сайдын яамаа нээсэн нь Төв Азийг өргөн хүрээнд харах "цонх" юм




Аливаа улсад ЭСЯ-аа нээнэ гэдэг тус улстай тогтмол харилцах боломж нээгдэж байна гэсэн үг. Айлчлалын үеэр Монгол Улсын Элчин сайдын яамыг Ташкент хотноо нээлээ.

Тус улсад Элчин сайдын яамаа нээснээр хоёр улсын худалдаа, эдийн засаг, аялал жуулчлал, боловсролын салбар дахь харилцаа өргөжинө. Ялангуяа, аялал жуулчлалын салбарын хөгжилтэй уялдуулж, Улаанбаатар-Ташкент чиглэлийн шууд нислэгийг бий болгох нь зүйтэй.

Түүнчлэн хот байгуулалт, тохижилт, тэр дундаа "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хамтын ажиллагаа өрнүүлэх боломж бий.

## Монгол Улсын Төрийн тэргүүний гадаад улсад хэрэгжүүлсэн айлчлал



2024.10.10-13

## Туркменистан Улсад төрийн айлчлал хийв

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ТУРКМЕНИСТАН УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ СЕРДАР БЕРДЫМУХАМЕДОВЫН УРИЛГААР 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 10-13-НЫ ӨДРҮҮДЭД ТУС УЛСАД ТӨРИЙН АЙЛЧЛАЛ ХИЙВ.

Хоёр улсын төрийн тэргүүн нар өнгөрсөн 30 гаруй жилийн ололт амжилтаа дүгнэж, ирэх он жилүүдийн хамтын ажиллагааны хэтийн төлөв, тэргүүлэх чиглэлээ тодорхойлж, харилцааны түүхэн шинэ хуудсыг хамтдаа нээж буйд баяртай байгаагаа илэрхийлэв.

Айлчлалын үеэр дараах баримт бичигт гарын үсэг зурав. Үүнд:

1. Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Туркменистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр,

2. Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Туркменистан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр,



3. Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Туркменистан Улсын Соёлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,

4. Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Туркменистан Улсын Соёлын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг,

5. Хөдөө аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Туркменистан Улсын Хөдөө аж ахуйн яам хоорондын хэлэлцээр,

6. Мал эмнэлэг, мал аж ахуйн салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Туркменистан Улсын Хөдөө аж ахуйн яам хоорондын хэлэлцээр,

Энэ нь хоёр улсын хооронд 1992 онд дипломат харилцаа тогтоосноос хойших хугацаанд Монгол Улсын төрийн тэргүүний түвшинд анх удаа хэрэгжүүлсэн айлчлал болов.

7. Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Туркменистан Улсын худалдаа, аж үйлдвэрийн танхим хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг.

## “Цаг үе, соёл иргэншлийн хэлхээ холбоо – Энх тайван, хөгжлийн үндэс суурь” форумд хүндэт зочноор оролцов



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Туркменистан Улсад хийсэн төрийн айлчлалынхаа хүрээнд “Цаг үе, соёл иргэншлийн хэлхээ холбоо – Энх тайван, хөгжлийн үндэс суурь” олон улсын форумд хүндэт зочноор оролцож, нээлтийн үйл ажиллагаанд үг хэлэв.

Ерөнхийлөгч форумын хүрээнд улс орнуудын төрийн тэргүүн нартай уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа болон бүс нутаг, олон улсын тавцан дахь асуудлаар санал солилцов.

Энэхүү форумыг Туркменистаны төр, Засгийн газраас тус улсын нэрт яруу найрагч, сэтгэгч Махтумгулы Фрагигийн мэндэлсний 300 жилийн ойд зориулан зохион байгуулсан юм. Тус форумд Армени, Иран, Казахстан, Киргиз, Пакистан, Орос, Тажикистан, Узбекистан зэрэг улсын төрийн тэргүүн болон Азербайжан, Ирак, Турк улсаас өндөр түвшний төлөөлөгчид оролцов.



2024.7.27

## “Парис-2024” зуны Олимпын нээлтэд оролцов

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ГЭРГИЙ Л.БОЛОРЦЭЦЭГИЙН ХАМТ БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ЭММАНУЭЛ МАКРОН, ОЛОН УЛСЫН ОЛИМПЫН ХОРООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ ТОМАС БАХ НАРЫН УРИЛГААР “ПАРИС-2024” ЗУНЫ ОЛИМПЫН XXXIII НААДМЫН НЭЭЛТЭД ОРОЛЦОВ. ЕРӨНХИЙЛӨГЧ У.ХҮРЭЛСҮХ ФРАНЦ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ ЭММАНУЭЛ МАКРОНТОЙ ТУСГАЙЛСАН УУЛЗАЛТ ХИЙВ.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Парис-2024” зуны Олимпын үеэр “Ла Вилетт” цэцэрлэгт хүрээлэн дэх “Монгол хаус” хотхонд зочлов.

Энэ үеэр уртын дуу, ардын хөгжим, бий биелгээ, уран нугаралт тэргүүтэй үндэсний урлагийн үзүүлбэрийг толилуулж, бөх, сур, шагайн харваа, монгол наадгай зэрэг уламжлалт спорт, тоглоомыг таниулан монгол орноо сурталчлав.



Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Олимпод оролцож буй тамирчдадаа амжилт хүсэв.



# БАЙР СУУРЬ

Гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах бодлого нь Монгол Улсын дотоод, гадаад бодлого, ардчилал, шинэчлэлийн үйл явцыг улс түмэнд сурталчлан таниулах, тэдэнд улс орныхоо талаар эерэг ойлголт, сэтгэгдэл төрүүлэх, найрсгаар хандан талархагчдын хүрээг өргөтгөх, иргэд хоорондын харилцаа, харилцан зорчих явдлыг нэмэгдүүлэхэд оршино.

*Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалаас*

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД Б.БАТЦЭЦЭГ:

## Эмэгтэйчүүдийн дуу хоолойг дэлхий дахинд хүчтэй илэрхийлэх талбар болгохыг зорьж ажиллалаа



Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгтэй ярилцлаа.

-Олон улсын манлайлагч эмэгтэйчүүд, улстөрч, бизнес эрхлэгч, нийгмийн зүтгэлтнүүд Улаанбаатар хотноо хуран чууллаа. Энэ хурлыг яагаад манай улс зохион байгуулав, ач холбогдлыг нь хэрхэн үнэлж байна вэ?

-Монгол Улсын гадаад харилцаа сүүлийн жилүүдэд маш идэвхтэй

өрнөж байна. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заасан чиг шугамын хүрээнд гадаад харилцааг тэлэх, тэнцвэртэй авч явах, дэлхийн бүх улс оронтой найрсаг харилцаа тогтоохыг эрмэлзэж, энэ зорилтоо ч сайн биелүүлж яваа. Түүнчлэн Монгол Улс жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн манлайллын асуудлаар бүс нутагтаа төдийгүй олон улсад ихээхэн санаачилгатай, олон улсын анхаарлыг татаж буй орны тоонд орж байна. Тиймээс

олон улсын эмэгтэйчүүдийг Монгол Улсад цуглуулж, дэлхийн асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах, уг асуудлаар манай улс юу хийж чадах вэ гэдгээ илэрхийлэхээр уг санаачилгыг гаргасан юм. Монгол Улсын саналыг НҮБ маш таатай хүлээж авсан.

Ингээд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор "Дэлхийн эмэгтэйчүүдийн форум" хэмээх маш амбицтай, хариуцлагатай чуулганыг НҮБ-тай хамтарч анх удаа эх орондоо зохион байгууллаа. Тус чуулганаар



эмэгтэйчүүдийн дуу хоолойг дэлхий дахинд хүчтэй илэрхийлэх зорилгыг агуулж ажиллалаа. Өөрөөр хэлбэл, Тогтвортой хөгжлийн зорилгыг биелүүлэх, нөгөө талдаа уур амьсгалын өөрчлөлт зэрэг хүн төрөлхтний өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд эмэгтэйчүүдийн оролцоо, манлайллыг хангах, шилдэг туршлагыг солилцох чухал индэр болгохыг бид эрмэлзсэн гэхэд болно.

**-Эмэгтэйчүүдийн манлайлал яагаад чухал вэ. Монголчуудын ямар сайн туршлагыг даян дэлхийн эмэгтэйчүүдтэй хуваалцахыг зорив?**

-Дэлхийн хүн амын 51 хувийг эмэгтэйчүүд эзэлдэг. Эмэгтэйчүүд амгалан тайван, үр хүүхдийнх нь эрүүл байдлаас энэ дэлхийн амар амгалан хамаарна. Гэвч шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй бага хувьтай байна. Тэгэхээр энэ асуудалд Монгол Улсын хувь нэмэр юу байж болох вэ, бидэнд ямар боломж байна вэ, юуг санал болгож, ямар санаачилгыг өрнүүлэх вэ гэдэг нь дэлхийн улс орнуудад сонирхолтой байсан байж мэдэх юм.

Бидний хөгжсөн онцлог, агуу түүх, нүүдэлчний соёл, дэлхийг илбэн тохинуулсан дээдсийн маань үйл хэрэгт эмэгтэйчүүдийн оролцоо, өнөөг хүртэл уламжилж ирсэн монгол эмэгтэйн манлайлал тодорхой хэмжээгээр үнэлэгдэж, анзаарагдах, шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх боломжтой гэж эмэгтэй хүнийхээ хувьд үздэг. Ер нь олон улсын үйл ажиллагаанд оролцож байхад монгол эмэгтэйчүүдийн манлайлал маш өндөр байгаа нь ажиглагддаг. Түүнчлэн

Монгол Улсад эмэгтэйчүүдийн эрхийг нэн эртнээс хангаж ирсэн. Аль ч төр засгийн үед эмэгтэйчүүдийн дуу хоолой хүчтэй байсан. Энэ бүхэн нь зарим орны хувьд хүрэхийг хүсдэг томоохон дэвшил болох нь харагддаг. Энэ онд Монголын эмэгтэйчүүдийн холбооны 100 жилийн ой тохиолоо. Тиймээс энэ хурлыг товлосон хугацаа ч учиртай юм.

Тус чуулганд оролцогчид уур амьсгалын өөрчлөлт, эдийн засгийн тогтворгүй байдал, хүйсийн тэгш бус түвшин зэрэг харилцан уялдаатай сорилтыг шийдвэрлэх зорилгоор байгаль орчинд чиглэсэн үйл ажиллагаа, хүнсний тогтолцоо, эдийн засаг, боловсрол, спорт, урлаг, соёлын салбар зэрэг 6 сэдэвчилсэн хуралдаанд оролцож, чуулга уулзалтын дүнгээр гаргах төгсгөлийн баримт бичгийг гаргалаа.

Жендэрийн тэгш байдлыг хангасан улс орнуудын статистикаар Монгол Улс нэлээд дээгүүрт жагсдаг. Ялангуяа 2024 оны УИХ-ын сонгуульд эмэгтэйчүүдийн оролцоог 30 хувь байхаар хуульчилсан. Энэ бол улс төрийн бодит манлайлал. Үүний үр дүнд УИХ-ын 126 гишүүний 32 нь эмэгтэйчүүд болсон.

**-Өнгөрсөн жил Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалтыг амжилттай зохион байгуулсан. Энэ удаагийн чуулганыг тэдгээрийн үргэлжлэл гэж хэлж болох уу?**

-Тийм ээ, Монгол Улсын гадаад харилцаа дотооддоо төдийгүй олон

улсад тодорхой хэмжээнд үнэлэгдэх болжээ. Монголын энхийг сахиулагчдыг мэдэхгүй хүн дэлхийд ховор болж, монгол цэргийн чадвар, нэр хүнд, тэсвэр тэвчээр гайхагдаж байна. Монгол Улс 20 жилийн хугацаанд 20 гаруй мянган цэргийг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулж, дэлхийн эмзэг цэгүүдэд үүрэг гүйцэтгүүлээд байна. Тиймээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаа-



чилгаар 2022 онд Эмэгтэй энхийг сахиулагчдын олон улсын анхдугаар хурлыг зохион байгуулсан. Цаашид үүнийг 4-5 жилийн давтамжтай зохион байгуулна. Мөн өнгөрсөн жил болсон Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалтаар дайнтай, ковидтой, дэлхий даяараа олон улсын дэг журам, харилцаанд маш их өөрчлөлт орж байгаа шилжилтийн гэмээр үед олон оронд тулгарч буй асуудлуудыг





шийдвэрлэхэд эмэгтэй сайд нар ямар хувь нэмэр оруулах боломжтойг хэлэлцсэн.

Өдгөө НҮБ-ын гишүүн 193 орны 40 орчим нь эмэгтэй Гадаад харилцааны сайдтай болжээ. Тэд бол маш хүчирхэг улстөрчид. Долоо, найман жилийн өмнө намайг дэд сайдын алба хашиж

байх үед энэ тоо 20 гаруйтай л байсан. Түүнчлэн 2025 онд эмэгтэйчүүдийн бас нэг тодорхой сэдвийн хүрээнд олон улсын хурлыг эх орондоо зохион байгуулах төлөвлөгөөтэй байна. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг 2026 онд эх орондоо зохион байгуулах



бэлтгэл ажлыг эхлүүлээд байна.

**-Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалтыг нээх үеэр Монгол Улс жендэрийн тэгш байдлыг хуульчилсан Азийн анхдагч улсуудын нэг гэж Та хэлсэн үгэндээ тэмдэглэж байсан. Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулганыг "Ногоон хөгжлийн төлөө" уриан дор зохион байгуулсан нь монгол ахуй, соёлын онцлогийг тусгасных гэж үзэж болох уу?**

-Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой, "Тогтвортой байдлыг хангах-2030" зорилтын хүрээнд маш олон үүрэг амлалтыг улс орон бүр авсан. Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлттэй маш сайн тэмцэж буй, идэвх санаачилгатай орнуудын тоонд багтдаг. Уур амьсгалын өөрчлөлт нь цаг зуурын өвчин зовлон, хүнсний хомсдол, эдийн засгийн хямрал зэрэг олон сөрөг үр дагаврыг дагуулдаг. Тиймээс энэ удаагийн чуулганы салбар хуралдаануудыг нэлээд прагматик, хүртээмжтэй, олон асуудлыг хэлэлцэх байдлаар зохион байгуулсан. Яагаад "Ногоон хөгжлийн төлөө" юм бэ гэхээр, бид эх дэлхийгээ хайрлах

ёстой. Үүнд эмэгтэйчүүд хамгийн том хувь нэмэр оруулж ирсэн.

Монголын нүүдэлч ахуй гайхалтай шүү дээ. Монголчууд минимал амьдардаг, нүүдэлчид байгаль орчноо хамгаалдаг, хог тарьдаггүй, аж ахуйч байсан. Өнө эртнээс уламжилж ирсэн энэ арга ухаан нь "Ногоон хөгжлийн төлөө" гэдэгтэй нийцдэг. Энэ нь гадаадын зочдод шинэлэг, сонирхолтой, заавал үзэх ёстой нэг соёл нь байх болов уу.

Монголд ирээд буцсан хүн бүр дахин ирэхийг хүсдэг, Монгол Улсыг олон улсад зөвөөр таниулж буй сэдэв нь яах аргагүй энэ юм.

**-Холын зочдоо хүндэтгэлтэй угтдаг монгол сайхан уламжлал бий. Монголд анх удаа болсон энэхүү чуулга уулзалтад хэчнээн орны төлөөлөгч хүрэлцэн ирэв. Хүндэт зочдоос онцлон дурдах уу?**

-Төр засгийн тэргүүн, Парламентын дарга, Гадаад харилцааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдууд, олон улсын эмэгтэйчүүдийн болон төрийн бус байгууллагын тэргүүн нар, мөн урлаг соёл, спорт, бизнесийн төлөөллөөс бүрдсэн гадаадын 100 гаруй зочин төлөөлөгч



оролцлоо. Тухайлбал, НҮБ-ын орлогч дарга, Словенийн ерөнхийлөгч, төв Азийн орнуудаас парламентын дэд даргын түвшинд хоёр ч орны төлөөлөл оролцлоо.

**-Дэлхийн олон орны эмэгтэйчүүдийн анхаарлын төвд Монгол Улсын 40 дэх гадаад харилцааны сайд байсан. Та ажилдаа ямар чанарыг эрхэмлэдэг вэ?**

-Би аливаа зүйлээс сайн талыг нь

олж харахыг хичээж, эерэг байхыг эрмэлздэг. Аливаа үйл ажиллагааг зохион байгуулахад аль болох үндэстнийхээ давуу талыг харуулах, түүнд нь манлайлж үлгэрлэх тийм хүрээлэл, орчныг хүсдэг. Тийм учраас энэ удаагийн хурал гадаадын зочдод маш сайхан дурсамж үлдээсэн, гайхалтай сайхан уур амьсгал дунд өрнөсөн байх гэж найдаж байна.



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ГАДААД БОДЛОГЫН ЗӨВЛӨХ Э.ОДБАЯР:

## Монгол Улсын гадаад бодлогын амин зүрх нь харилцан ашигтай тэнцвэртэй харилцаа



Монгол Улсын Ерөнхийлөгчийн гадаад бодлогын зөвлөх Э.Одбаяртай Монгол Улсын гадаад харилцаа, гадаад бодлогын үзэл баримтлалын талаар ярилцлаа.

**-2024 он Монгол Улсын гадаад харилцааны хувьд онцгой чухал жил боллоо. Түүхэндээ нэг жилийн дотор 9 төрийн болон албан ёсны айлчлал хүлээж авсан тохиолдол урьд нь байгаагүй байх, тийм үү?**

-Монгол Улсын гадаад харилцаа гадаад бодлогынхоо үзэл баримтлалын дагуу үнэхээр идэвхтэй, үр өгөөжтэй, эрчимтэй өрнөж байна. Энэ онд есөн орны төрийн тэргүүнийг улсынхаа нийслэл Улаанбаатарт хүлээн авч, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны талаар ярилцаж, зарим оронтой нь өнгөрсөн 30, 50, 70 жилд хамтарч ажилласан түүхэн замналаа дүгнэж, дараагийнхаа алхмыг тодорхойлсон үнэхээр сайхан жил боллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 онд Ерөнхийлөгчөөр сонгогдсоноос хойш айлчлалуудын тоо нэмэгдсэн, тэдгээр айлчлалын хүрээнд ярьсан

сэдэв, түүний мөрөөр хийх ажлын төлөвлөгөө, хийж буй ажлыг харсан ч гадаад харилцаа сэргэж, идэвхтэй, үр өгөөжтэй, эрчимтэй өрнөж байна хэмээн дүгнэж болохоор байгаа.

Нэн ялангуяа, "Ковид 19" цар тахлын дараа дэлхий ертөнцөд харилцан ажиллах дэг журам өөрчлөгдөж, дайн дажин, зэвсэгт мөргөлдөөн, үл ойлголцол, үл итгэлцэл өрнөж буй энэ үед манай улсын гадаад бодлого харьцангуй идэвхтэй, нээлттэй, олон тулгуурт зарчмынхаа хүрээнд, Монгол Улсын гадаад ертөнц дэх нэр төр үнэт зүйл, үүх түүх, өв соёл, ёс заншлынхаа амин чанараар ялгарсан, танигдсан он жилүүд болж байна. Түүний дотор 2024 он бол яах аргагүй гадаад харилцааны салбарт хамгийн олон айлчлал түүхэндээ авсан, үр өгөөжтэй, харилцан ашигтай хамтын ажиллагааг эрчимтэй бөгөөд үр бүтээлтэй ярьж чадсан оргил жил боллоо.

**-Монгол Улс мөнхийн хоёр хөрштэй. Халх голд хамтын ялалт байгуулсны түүхт 85 жилийн ойн хүрээнд манай улсад ОХУ-ын төрийн тэргүүн айлчилсан. Мөн уламжлалт найрсаг хамтын ажиллагаатай орнуудын төрийн тэргүүн нар ч айлчиллаа. Ер нь дэлхийн улс төрд Монголын үнэ цэн юу вэ?**

-Их сайхан асуулт байна. Энэ олон улсын айлчлал хэрэгжүүлээд гадаадад идэвхтэй бодлого явуулснаараа монголчууд бид ямар үнэт зүйлийг таниулах, манай улсын үнэ цэн юу вэ гэхээр өвөг дээдсийн маань бүтээсэн төрт ёсны 2500-гаад жилийн түүх, монголчууд бидний өв соёл, дэлхийд ялгарч байгаа нүүдэлчин соёл иргэншил маань гэж би хэлэх дуртай. Нүүдэлчин соёл иргэншлийг тээгч гол улсын хувьд, Их Монгол улсын гал голомтыг сахин суугаа ард иргэдийн хувьд, бусад улс оронтой адилхан болох гэж биш, харин өөрсдийнхөө онцлог, үнэт зүйл, үүх түүх, өв соёлоор бахархсан, түүнийгээ зөв зүйтэй таниулсан, түүндээ тулгуурлаад харилцан ашигтай хамтын ажиллагааны талаар ярилцах ёстой гэдгээ ойлгуулах нь чухал байгаа юм.

Үүнийг олон улсын хэмжээнд дипломат үйл ажиллагаагаар гүйцэлдүүлэх энэ гол үйлсэд манай улсын тэргүүн дипломатч, Монгол Улсын Ерөнхийлөгч манлайлж, Монгол Улсын хоёр хөрш, гуравдагч хөрш болон олон улсын байгууллагууд, бусад түнш, ахан дүүсийн хэлхээ холбоотой, уламжлалт найрсаг харилцаатай улс орнуудын тэнцвэрийг олсон, тэнцвэрийг хангасан, харилцан ашигтай хамтын ажиллагаанд суурилсан гадаад


харилцаа, гадаад бодлогыг явуулж байна.

Тэгэхдээ бусдыг аялдан дагах, урсгал даган урсах биш, зарим үед урсгал сөрөх, зарим үед өөрсдийнхөө үнэт зүйлийг тайлбарлах, монголчууд бид ийм язгуур эрх ашигтай учраас ийм бодлого явуулж байгаа гэдгээ олон улсын хамтын нийгэмлэгт танилцуулж, ойлгуулж байж язгуур эрх ашгаа хамгаална.

Бид даяаршсан ертөнцөд амьдарч байгаа учраас олон улсын хэмжээнд нээлттэй, олон тулгуурт, энхийг эрхэмлэсэн бодлого явуулж байгаа. Энэ нь ч олон улсын хэмжээнд маш том дэмжлэг авч байна. Түүнчлэн НҮБ-аас баталсан "Тогтвортой хөгжлийн зорилт" нь манай улсын "Шинэ сэргэлтийн бодлого", "Алсын хараа-2050" гээд бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа учраас манай улстай хамтарч ажиллах түншүүдийн бидний талаарх ойлголт сайжрах, улам гүнзгийрэх ёстой юм.

Монгол Улс тусгаар тогтносон, бие даасан өөрийн гэсэн гадаад бодлоготой улсын хувьд манай улсын тусгаар тогтнол өөрөө бидний хамгийн том үнэт зүйл. Тэгэхээр энэ тусгаар тогтнолоо хадгалан хамгаалах, бэхжүүлэх ажлыг улс төр дипломатын аргаар цогцлоох үйл хэрэг энд явагдаж байна гэсэн үг юм.

**-Монгол Улсад энэ жил дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалт болсон. Өнгөрсөн жил Гадаад харилцааны сайд нарын уулзалт, түүний өмнө Энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн олон улсын хурал болсон. Ер нь, яагаад Монгол Улс эмэгтэйчүүдийг ийнхүү онцолж буй вэ?**





-Монгол Улсын Ерөнхийлөгч феминист гадаад бодлогыг дэмждэг. Жендэрийн эрх тэгш байдал, шийдвэр гаргахад эмэгтэйчүүдийн оролцоо зохих түвшинд байх ёстой, энд манлайлах хэрэгтэй байгааг олж харсан учраас өөрийнхөө ивээл дор олон олон үйл ажиллагааг жил болгон хэрэгжүүлж байна. Та 3 жишээг дурдлаа. Энэ жил түүхэндээ анх удаа Дэлхийн эмэгтэйчүүдийн форумыг Монгол Улс зохион байгууллаа. "Бээжингийн тунхаглал" баримт бичиг гарснаас хойш олон жилийн турш бодит, дорвитой томоохон үйл ажиллагаа зохион байгуулагдаагүй тул манлайллыг гартаа авч, эмэгтэйчүүдийн үүрэг оролцоо, олон улсын хэмжээнд харуулж буй ололт амжилтыг Монгол Улс ил болгоё, асуудлыг хамтарч сайжруульа гэх үүднээс маш олон сэдвийн дор дэлхийн эмэгтэйчүүдийн чуулганыг зохион байгуулсан. Тэгээд орчин үед ид яригдаж байгаа гол сэдвүүдтэй уялдуулаад "Ногоон хөгжлийн төлөөх Улаанбаатарын тунхаглал" гэж гаргасан. Энэ баримт бичгийн зүйл, заалтууд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолууд болон дэлхийн дээд хэмжээний уулзалтуудад дурдагдаж, баримт бичгүүдэд нь тусгагдаж байгаагаараа манай улс олон улсын хамтын нийгэмлэгийн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрх тэгш байдлын үйл хэрэгт томоос том хувь нэмэр оруулсан гэж үзэж болно.

Ийнхүү олон улсын хурал цуглаан манай улсад болох нь бас эдийн засгийн үр ашигтай. Гадаадын зочид төлөөлөгчид зочид буудалд бууна, монгол хоол иднэ, монгол өв соёлтой танилцана. Нөгөөтэйгүүр аливаа асуудлаар дотооддоо яриад зогсохгүй, олон улсын том үйл явдалд хувь нэмрээ оруулах боломжтой, чадалтай болсон гэдгээ харуулдаг.

Түүнчлэн бүс нутгийнхаа улс орнуудтай харьцуулахад манай улс хуваалцах ололт амжилт, баялаг туршлагатай улс юм. Үндсэн хуульдаа эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн эрх тэгш байдлыг баталгаажуулсны 100 жилийн ой боллоо. Энэ жил Монголын эмэгтэй-

чүүдийн холбооны 100 жилийн ой мөн тохиосон. Тэгэхээр бид бүс нутагтаа жендэрийн асуудлыг дөнгөж саяхан ойлгож сэхээрээд байгаа улс биш юм. Манай улс олон улсын хэмжээнд ямар ач холбогдол, ямар үнэт зүйлтэй улс вэ гэдгээ бас нэг хэлбэрээр таниулж байгаа учраас эмэгтэйчүүдийн чуулган, Гадаад хэргийн эмэгтэй сайд нарын уулзалт, Энхийг сахиулагч эмэгтэйчүүдийн хурал нь манай гадаад бодлого улс төр, олон улсын харилцаа, энхийг сахиулах үйл ажиллагаа, НҮБ-ын оролцоотой хүртэл салшгүй уялдаа холбоотойг олон улсад таниулж байгаагаараа өндөр ач холбогдолтой.

**-Дэлхийн эмэгтэйчүүдийн форумыг маш амжилттай болсныг чуулганд оролцогчид илэрхийлж байсан. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 79-р чуулган, түүний өмнө ШХАБ-ын гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд ажиглагчаар оролцсон. НҮБ, Монголын харилцааны онцлог талыг хэрхэн тодорхойлж болох вэ?**

-Манай улс НҮБ-ын идэвхтэй бөгөөд хариуцлагатай гишүүн, гадаад харилцааны олон талт дипломат үйл ажиллагааг дэмжигч улс орны хувьд НҮБ-тай онцгой, ойрхон харилцаатай.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерреш манай улсад айлчлахдаа "Дайн дажинтай энэ хэцүү цаг үед Монгол Улс энх тайвны бэлгэ тэмдэг болсон улс" гэдгийг тодорхойлж, олон улсын хэмжээнд тунхаглан таниулсан. Энэ бол манай улсын 60-аад жилийн турш НҮБ-ын бүрэн эрхт гишүүний хувиар хийсэн, бүтээсэн үйл ажиллагаа, идэвхтэй оролцооноос хийсэн дүгнэлт юм.

Түүнчлэн аливаа асуудлыг шийдэхэд олон талт механизмаар шийддэг энэ цаг үед НҮБ-ын гишүүн байх нь өндөр ач холбогдолтой. Маргааныг ч олон улсын хэмжээнд, олон улсын эрх зүйн дагуу, НҮБ-ын дүрмийн дагуу шийдвэрлэх нь зүйтэй гэдэг байр суурийг эрхэмлэдэг улс орны хувьд ч НҮБ-ын гишүүн байх нь ямар ач холбогдолтойг хамгийн сайнаар ойлгож байх ёстой улс бол манай улс юм. Зөвхөн манай улс ч гэлтгүй, манай улстай ижил төстэй нөхцөл байдалд байдаг, геополитик, геостратегийн нөхцөл байдал нь манайхтай төстэй жижиг улс орнууд, нэн буурай хөгжилтэй орнууд, арлын орнууд, далайд гарцгүй орнууд НҮБ-ын ач холбогдлыг сайн ойлгож байдаг.

Олон талт хамтын ажиллагааг эрхэмлэдэг гадаад бодлоготой манай улсын хувьд НҮБ чухлаас гадна, манай үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдлыг ханган хэрэгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой үүрэг гүйцэтгэдэг механизм юм. Тэр утгаараа НҮБ-тай Монгол Улс идэвхтэй, үр өгөөжтэй, харилцан ашигтай харилцааг цогцлоож явна. Тийм учраас олон улсын хэмжээнд энэ хурлуудыг НҮБ-тай хамтран зохион байгуулж байна.

Олон улсын хурлыг хамтран зохион байгуулах ач холбогдол нь юу вэ гэхээр, НҮБ-ыг олон жилийн турш хүмүүс донор байгууллага, мөнгөтэй байгууллага гэж хардаг байсан. Одоо больсон. НҮБ шиг баялаг



мэдлэг чадвартай туршлагатай байгууллага олон улсын хэмжээнд байхгүй. Тэгэхээр НҮБ-аас маш олон механизмыг бид суралцдаг, ашигладаг. Түүнчлэн олон улсын тэр харилцаа холбоо, хамтын ажиллагааны механизмуудаараа дамжуулаад түншлэлүүд их хурдацтай хөгжиж, үр дүн болж гарч ирдэг учраас НҮБ болон НҮБ-ын хүрээнд болж байгаа үйл ажиллагаануудад Монгол Улс идэвхтэй оролцдог. Мөн олон улсын үйл ажиллагаануудыг НҮБ-тай хамтран зохион байгуулдаг.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хуралдаан, чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч 2021 оноос хойш жил бүр биечлэн оролцож ирлээ. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн хүрээнд, 9 дүгээр сарын 17-28-нд Нью-Йорк хотноо маш олон уулзалт болж, хоёр талын болон олон талт асуудлаар санал бодлоо солилцдог. НҮБ-ын гишүүн 192 оронтой тэнд уулзах боломж олддог. Тиймээс цаг, зардал хэмнэсэн, их үр өгөөжтэй хурал болдог. Тэгэхээр энэ хуралд бид өндөр ач холбогдол өгч оролцохоос өөр аргагүй.

Монгол Улсын Ерөнхийлөгч мөн СОП хурлууд буюу уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэх гол бодлогыг ярьдаг энэ хуралд жил болгон оролцож байна. ШХАБ-ын өргөтгөсөн хуралдаанд ч гэсэн ажиглагчийн хувиар жил болгон оролцож байна.

**-Монгол Улсын Ерөнхийлөгч 2024 онд Туркменистан, Узбекистан улсад л төрийн айлчлал хийсэн. Энэ нь эдгээр улстай явуулах харилцаанд мөн ихээхэн ач холбогдол өгч байгаагийн илэрхийлэл болов уу. Ер нь Төв Азийн орнуудтай харилцааг бэхжүүлэхийн ач холбогдол, үнэ цэн юу вэ? Төв**

**Азийн орнуудын хөгжлийн хэтийн төлөв ямар байна вэ?**

-Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2021 оноос хойш зарчмын хэд хэдэн өөрчлөлтийг хийж байна. Нэгдүгээрт, "Дэлхийг Монголд" гэдэг зарчмыг баримталж байна. Энэ бол өөрсдөө гадагшаа айлчлах тоогоо тодорхой хэмжээнд бариад, гадаадын зочдыг Монголдоо, улс орныхоо нийслэлд урьж, хоёр талын харилцааг ярилцъя, энэ нь илүү ач холбогдолтой, илүү үр дүнтэй хэмээн үзэж байна.

Үүнээс гадна харилцан ашигтай хамтын ажиллагааг өрнүүлж гэдэг зарчмын том өөрчлөлтийг хийж байна. Энэ нь айлчлал болгоны дараа ямар хэмжээний мөнгө авч ирэв, хэдий хэмжээний тусламж олж ирэв гэж байнга асуудаг байсан хандлагыг халж, харилцан ашигтай хамтын ажиллагааг ярья гэж байгаа юм.

Тэгэхээр "Дэлхийг Монголд" гэдэг уриа амжилттай явагдаж байгаагийн тод илрэл нь 2024 он боллоо шүү дээ. Гадаад харилцааны түүхэндээ бид анх удаа 9 төрийн болон албан ёсны айлчлалыг нэг жилдээ багтааж хүлээж авлаа. Харин Ерөнхийлөгч маань Төв Ази руу чиглэсэн бодлогоо үргэлжлүүлж Узбекистан, Туркменистан улсад айлчиллаа.

Тэгэхээр таны асуусанчлан, сүүлийн үед Төв Ази чиглэл Монгол Улсын гадаад бодлогод нэлээн их анхаарал татаж, том байр суурь эзлээд байгаагийн учрыг гурван зүйлээр тайлбарлая.

Нэгдүгээрт, бид бол далайд гарцгүй хөгжиж буй орнууд, Монгол Улс 15 жилийн өмнө Улаанбаатарт Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын олон улсын

судалгааны төвийг байгуулсан. Бид далайд гарцгүй 32 улс, хөгжиж байгаа улсуудын эрх ашгийг олон улсын худалдаа, тээвэр логистикийн асуудалтай нь хамтын хүчээр хамгаалах ёстой байгаа юм.

Хоёрдугаарт, Төв Азийн эдгээр улс Монголтой адилхан цөлжилтийн асуудалтай болсон. Ялангуяа, Казахстан, Киргизстан манайхтай адилхан мал аж ахуй, хөдөө аж ахуйн эдийн засаг зонхилсон орнууд юм. Тэгэхээр 2026 онд бид НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын Талуудын 17 дугаар бага хурлыг Улаанбаатарт зохион байгуулна. Энэ тал дээр байр сууриа нэгтгэх, дэлхийд дуу хоолойгоо хүргэхэд хамтарч ажиллах нь чухал байгаа юм.

Гуравдугаарт, Төв Ази нь бараг 80 сая хүнтэй том зах зээл. Дээр нь тэнд асар их хүчтэй эрчим хүчний бодлого, тоглогчид, нөөцүүд байна. Цаанаас нь Ойрх Дорнод, Арабын том том хөрөнгө оруулагчид, ноу-хау (know-how) орж ирнэ. Тэгэхээр бид энэ Төв Азид чиглэж байгаа энэ том ирээдүй рүү, маш эрч хүчтэй хөгжиж байгаа эдийн засаг руу анхаарах хэрэгтэй юм.

**-Монгол Улсын гадаад харилцааны салбарт хэрэгжүүлж буй бодлого зохих ёсоор дэлхий дахины анхаарлыг татсан, гадаад харилцааны салбарт сэргэлт хийсэн нэгэн оныг бид үдэж байна. Тэгвэл 2025 он гадаад харилцааны хувьд ямар жил болох бол?**

-Монгол Улсын гадаад харилцаандаа тэнцвэртэй гадаад бодлогыг явуулах нь бас амин чухал юм. Хоёр хөршийн харилцаа, гуравдагч хөршийн харилцаа, олон улсын байгууллагуудтай хөгжүүлж байгаа харилцаа болгоны хоорондын тэнцвэр их чухал байдаг.

Тэгэхээр та бүхэн ажигласан байх, 2021 оноос хойш хэрэгжүүлсэн айлчлал болгоны цаад учир утга нь энэ тэнцвэр, энэ балансад анхаарсан явдал байсан. Үүнийг их тодорхой жишээн дээр харуулж болно л доо. Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн гадаад айлчлалыг 2021 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейд оролцох ажлын айлчлалаар эхлүүлсэн. Үүний дараа Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалын тэргүүлэх чиглэл буюу 2 хөрштэйгөө эн тэргүүнд сайн харилцаатай байх үзэл баримтлалын дагуу ОХУ-д айлчилсан. Үүний дараа БНХАУ-д төрийн айлчлал хийсэн. Ингээд дараа нь Япон, Франц зэрэг гуравдагч хөршүүдтэйгээ айлчлал хэрэгжүүлсэн. Гуравдагч хөршүүдийнхээ ч манайх руу чиглэсэн айлчлалуудын тэнцвэрийг хангах нь их чухал байсан, үүнийгээ ч бид хангаж ажиллаж байна.

Зүүн өмнөд Ази руу чиглэсэн манай гадаад бодлогын хүрээнд Лаос, Вьетнам зэрэг оронд төрийн айлчлал хэрэгжүүлсэн. Түүхэндээ анх удаа бид Вьетнам улсыг гуравдагч хөршөө хэмээн тодорхойлж нэрлэв. Энд Вьетнамын андууд, түншүүд маань их нааштай хандаж, их баярласан. Өмнө нь зөвхөн өндөр хөгжилтэй барууны гэдэг юм уу, Азийн орнуудыг бид гуравдагч хөршөө хэмээн тодорхойлж байлаа шүү дээ.

Лаос, Вьетнамын Ерөнхийлөгч нарын манай

улсад хийсэн төрийн айлчлал нь цаанаа маш том өгүүлэмжтэй. Тэр нь юу вэ гэхээр, манай улс орнуудын уламжлалт найрсаг харилцаа сэргээд зогсохгүй, харилцан айлчлалын давтамж ойртсоноороо бидний хөгжүүлж буй харилцаа, хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл хэр сайн байгааг харуулсан. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгч өнгөрсөн жил тэдгээр оронд айлчилсан бол тэдгээр улсын Ерөнхийлөгч нар манай улсад энэ жил айлчилснаараа их ойрхон харилцаатай улс орнууд гэдгийг олон улсын түвшинд харууллаа.

Харин хөгжиж байгаа орнуудтайгаа яаж идэвхтэй ажиллаж байна гэвэл, Куба улсад болсон 77-гийн бүлэг буюу хөгжиж буй орнуудын бүлгийн хуралд Монгол Улсын Ерөнхийлөгч оролцсоноороо олон улсын хамтын нийгэмлэгийн хөгжиж байгаа орнуудын хүрээнд явуулж байгаа бодлогод ч гэсэн идэвхтэй оролцдог харуулсан чухал айлчлал болсон. Тэгэхээр тэнцвэрийг бид хэрхэн тодорхойлж байгааг илүү тод ярих үүднээс дээрх айлчлалуудыг бид дурдлаа.

Тэгээд энэ тэнцвэрийг хангана гэдэг нь өөрөө манайх шиг улсад их амаргүй ажил, гэхдээ бидний хувьд шинэ зүйл биш. Олон зуун жилийн өмнөөс монголчууд том гүрнүүдийн дунд амьдарч чадсан, амьдарч сурсан. Энэхүү том үүх түүхээсээ улбаалаад бид өнөөдрийнхөө гадаад бодлогыг явуулж байгаа. Тэгэхээр өнөөдрийн гадаад бодлогын амин зүрх нь харилцан ашигтай, тэнцвэртэй харилцаа юм.

Тэгэхээр 2025 он бол илүү идэвхтэй, олон улсын зочин гийчин олонтой, олон том хурал манай улсын нийслэлд зохиогдсон, төрийн айлчлалууд ар араасаа цуварсан, завгүй жил болох байх гэж бодож байна. Энэ жил улс орнуудын төрийн тэргүүн нар түлхүү ирсэн бол, дараа жилээс олон улсын хаад ноёд, амбан захирагч нар манай улс руу чиглэсэн, идэвхтэй харилцаа өрнөсөн ийм жил болох болов уу. Тэгээд мэдээж өнгөрсөн 3 жилийн идэвхтэй гадаад харилцаа, гадаад бодлогын хүрээнд яригдсан зүйлсийн биелэлтийг мөн хянах жил болно.

Монголчууд гадаад харилцаа, гадаад бодлогын хувьд нэг цонхоор гадагшаа харьцах зарчимтай. Бид эв найртай, нэг зүгт харсан, харилцан бие биеэ ойлгосон дүр зургийг гадаад ертөнцөд ойлгуулж харуулж байж амжилттай урагшилна. Олон улсад улсаа төлөөлөх эрх бүхий тэргүүн дипломатч нь Ерөнхийлөгч байдаг нь ийм ач холбогдолтой учраас манай улсын гадаад бодлого энэ эрч, эв нэгдэл, ойлголцол, эрч хүчээрээ цааш явах ёстой. Үүний илрэл нь 2025 он болно.

**-Улс эх оронд маань дэлхийн хүмүүс ирнэ гэдэг үнэхээр сайхан. Тэгэхээр Монгол Улс геостратегийн байршлаа зөв ашиглах тухай их ярьдаг. Өнөөгийн хэрэгжүүлж буй ийм идэвхтэй гадаад бодлогын дэргэд энэ нь жижиг асуулт уу?**

-Жижигхэн гэлтгүй асуух ёстой. Ер нь, жижиг орон эсвэл манайх шиг геостратегийн газар зүйн байршилтай улс орны хувьд байх ёстой асуулт л даа. Тэгэхээр хэд хэдэн өнцөг бий.



Нэг үнэн гэвэл, Монгол Улс газар зүйн хувьд дэлхийн хамгийн том 2 зах зээлийн дунд оршдог, ардчилсан улс. Манайд бараа бүтээгдэхүүн борлуулах нь сонин биш, харин урд, хойд талд 2 том зах зээл байна. Үүнийг зөв ашиглаж чадвал үйлдвэрлэгч, экспортлогч орон болох бол энүүхэнд. Нөгөөтээгүүр бид залуусын орон. Эрч хүчтэй, өөдрөг, эрчимт ард түмэн. Тиймээс бусад улс оронтой харьцуулахад хөл дээрээ маш хурдан босох, эрчимтэй хөгжих боломжтой.

Ард түмэн нь хийморьлог, нүдэнд нь гал бадарч байдаг, ямар ч зовлон зүдгүүр тулгарсан дасан зохицоод, эсвэл даван гарах чадалтай гэж боддог ард түмэн юм. Маш өндөр боловсрол эзэмшсэн, чадварлаг залуус олон байна. Олон мэргэжилтэн, олон эксперт ч манай улсад байна.

Хоёр том хөршөөр хүрээлүүлсэн, цоожлогдсон, далайд гарцгүй улс гэж харахаасаа илүүтэй энэ хоёрыгоо гарц болгож харах боломж байна. Энэ хоёр улсын бараа бүтээгдэхүүн дамжин өнгөрөх, Евроазийг холбосон бас нэг гүүр. Тиймээс бид энэ хоёр хөршийн хөгжлийн болон дэд бүтцийн стратегийн бодлогод нь бид өөрсдийнхөө бодлогыг уялдуулж, язгуур эрх ашгийг харж ажиллаж байгаа. Жишээлбэл, БНХАУ-ыг Оросоор дамжуулан Европтой холбох, Европыг бас Ази тивтэй холбох эдийн засгийн коридор нь манай улс байж болохыг бид харсан учраас "Бүс ба зам" санаачилгын хүрээнд, ОХУ-ын дэд бүтцийн томоохон төсөл бодлоготой бид уялдуулж "Талын зам", "Транзит Монгол" хөтөлбөрөө явуулж байгаа.

Өөр жишээ хэлэхэд, бид агаарын орон зайгаа ашиглан агаарын том зангилаа улс болох боломжтой. Манай улсаас дөрөвхөн цаг нисээд дэлхийн эдийн засгийн томоохон сүлжээг атгаж байдаг Хонконгод хүрнэ. Зүүн Азийн томоохон хөгжилтэй улс орнууд болох Солонгос, Япон руу 3-4 цаг нисээд очно. Зүүн өмнөд Ази гээд Азийн гол аж үйлдвэрийн бүс байгаа газар руу бид хоёроос гуравхан цаг нисээд хүрч байна. Тиймээс Зүүн хойд Азийн хүмүүнлэгийн агуулах, тусламжийн бараа бүтээгдэхүүнийг зохицуулалт хийж, тараадаг сүлжээ улс байх саналыг ч гэсэн дэвшүүлж байгаа.

Тэгэхээр бид нэг талаасаа геополитик, геостратегийн хувьд хаагдмал, далайд гарцгүй мэт боловч оюун санааны хувьд цоожлогдсон улс биш юм. Дээрээс нь геополитикийн хувьд ч гэсэн нөгөө өнцгөөс нь харвал, харин ч том гарцтай, том боломжтой улс гэж үзэж байгаа.

Дэлхийн далайд гарцгүй 32 орон байдгийн 16 нь Африкт байгаа. Төв Африкийн улс орнууд бол хөгжлийнхөө гарцыг олж хараад хөгжлөө ярихаар эргэн тойронд нь байгаа улс орнууд нь дайнтай, бас нэн буурай хөгжилтэй, жижигхэн зах зээлтэй улс орнууд байдаг. Харин бид маш том боломжтой улс. Урд талд маань хамгийн том зах зээл, хамгийн том үйлдвэрлэгч байна. Хойд талдаа ч маш хүчтэй, том зах зээлийг бид харж байна. Мэдээж энд хамгийн смарт буюу ухаалаг бодлого, стратегийн томоохон бодлого хэрэгтэй. Үүнийг л бид зөв зүйтэй хийх гэж ажиллаж байна.

## Д.Баярхүү: 2024 он Иж бүрэн түншлэлийн харилцааг шат ахиулсан жил боллоо



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайер манай улсад төрийн айлчлал хийсэнтэй холбогдуулж, айлчлалын ач холбогдол, үр дүн сэдвээр судлаач-профессор, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд асан Д.Баярхүүтэй ярилцлаа.

### -Хоёр улсын харилцааны түүхийг хамгийн товчоор хэрхэн тодорхойлж болох вэ?

-Хүйтэн дайны тэртээх хүндхэн цаг үед хурцадмал байдал түр намжсан цаг үе дор тухайн үеийн ХБНГУ-ын Засгийн газрын "Остполитик" гэх шинээн ухаалаг бодлогын дүнд БНМАУ-ыг хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа тогтоож байжээ. Эдүгээ хагас зуун өнгөрсөн байна. Харин Германы дорнод хэсэгт 1949 онд байгуулагдсан коммунист БНАГУ-тай 1950 онд дипломат харилцаа тогтоож, тэр улсыг 1990 онд татан буугдтал нь ах дүүгийн найрсаг харилцаатай байсныг түүх өгүүлнэ. Германчуудтай 1950-иад оноос манай улс харилцаатай байж, тэр харилцаа нь 1990 онд хоёр Герман нэгдсэний дараа өнөөгийнхөө энэхүү идэвхтэй хамтын ажиллагаанд дэвшин хөгжсөөр иржээ гэж дүгнэж байна даа.

### -Германы талтай бид түншлэлийн ямар түвшинд хамтран ажиллаж байна вэ. Өмнө нь ямар төсөл хөтөлбөрүүд дээр хангалттай үр дүнтэй хамтарч байв?

-Монгол-Германы харилцаа 1990-ээд оны бүр эхнээс л эрчээ авсан. Монгол дахь ардчилал, шинэчлэл, нээлттэй нийгэм, зах зээлийн харилцаа руу хийх шилжилт, эрх зүйт төрөө эмхлэн байгуулах гээд монголчуудын 30 гаруй жилийн чармайлтыг бүр анхнаас нь Герман дэмжсэн.

Төсөл хөтөлбөрүүд гэж асууж байгаа бол бүгд л амжилттай хэрэгжсэн гэж хэлнэ. Харилцаа, хамтын ажиллагаа олон салбарт хөгжиж байна. Харилцаа, хамтын ажиллагааны голлох чиглэл, салбаруудыг 2008 онд тунхагласан "Иж бүрэн түншлэл"-ийн харилцаанаас тодруулж болно.

Манайхны хувьд гайгүй үр дүн хүртсэн зураглал надад буудаг. 1991 оноос хойш манай улсад 529.6 сая еврогийн буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн. Манай эдийн засгийн үзүүлэлт харьцангуй сайжирч, хүн амын орлого нэмэгдсэн үндэслэлээр Германы тал 2020 онд хөгжлийн албан ёсны дэмжлэг, буцалтгүй тусламжаагаар түр зогсоогоод, 2022 оноос дахин сэргээсэн. 2023 оны 9 дүгээр сард Улаанбаатарт болсон Засгийн газар хоорондын хэлэлцээний дүнд ХБНГУ ирэх 2-3 жилд нийт 78 сая еврогийн хөнгөлөлттэй зээл, тусламж олгоно. Үүнд санхүүгийн хамтын ажиллагааны төслүүдэд 17 сая евро, техникийн хамтын ажиллагааны төслүүдэд 22 сая евро, сүрьеэ, ДОХ, хумхаа өвчинтэй тэмцэх "Глобал" сангаар дамжуулан эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр санхүүжүүлэхэд 29 сая евро төсөвлөгдсөн мэдээ байна билээ.

### -Эдийн засгийн харилцааг гүнзгийрүүлэхэд талууд хэрхэн ажиллаж байна вэ?

-Худалдаа-эдийн засгийн хамтын

ажиллагаа бол чухал чиглэл. Манай улсын боломж хязгаарлагдмал болохоос Герман бол дэлхийн топ эдийн засгуудын нэг, ямар л бол ямар хэлбэрээр, тоон дүнгээр хэчнээн ч сая тэрбумаар худалдаа арилжаа явуулах том улс шүү дээ. Худалдааны эргэлтийг сая ам.доллараар авч үзвэл, чамлалттай санагддаг. Сүүлийн 5 жилийн статистик байна. Монгол Улсад 1990-2023 онд ХБНГУ-ын 113 хуулийн этгээд нийт 279 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь манай улсын нийт гадаадын шууд хөрөнгө оруулалтын 0.7 хувь байгаа нь бас л чамлалттай үзүүлэлт. Энэ талаар монголчууд бид өөрсдөө хичээх шаардлагатай.

### -Сүүлийн үед хэрэгжүүлж буй айлчлалуудыг харахад манай улстай уул уурхайн салбарт хамтарч ажиллах сонирхол давамгайлах болжээ гэж харж байна?

-Уул уурхай гэснээс Германтай "Ашигт малтмал, аж үйлдвэр болон технологийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр" ХБНГУ-ын Холбооны Канцлер А.Меркелийг 2011 онд манай улсад албан ёсоор айлчлах үеэр байгуулсан. Уул уурхайн салбарт хамтын ажиллагааны өвөрмөц хэлбэр туршлагатай болсон. Уул уурхайн хамтарсан бизнес эрхэлье гэвэл болохгүй зүйл, Германы талаас шалтгаалах зүйл гэж байхгүй. Гэхдээ уул уурхайг хөдөлгөх үндэсний инженер, техникийн ажилтан, менежерүүдийг нь сургаж бэлтгэх нь оновчтой гэж айлын тал үзсэн юм болов уу. Хоёр улсын Засгийн газрын санаачилгаар Монгол-Германы хамтарсан Ашигт малтмал, технологийн их сургууль (GMIT)-ийг 2014 онд байгуулаад ажиллаж байна. Тус их сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд 421 оюутан суралцаж байна. 2018-2023 онд төгссөн нийт 155 төгсөгчид 100 хувь ажлын байраар хангагдсан. Нийт оюутны 40 хувь нь тэтгэлэгтэй суралцаж байна. Энэ бол том амжилт биш гэж үү? Гэхдээ монголчууд бид-

нээс их зүйл шалтгаална. Европ дахь чухал гуравдагч хөрш Германыг зөв оновчтой, харилцан ашигтайгаар ашиглаасай гэж бодож байна.

### -Хоёр орны харилцааны нэг талбар бол төрийн бус байгууллагууд, тэдгээрийн идэвхтэй үйл ажиллагаа байдаг. Энэ талын харилцаанд дээр манай улс тэдний тавьж буй асуудлыг хэр анхааралтай чагнаж, хүлээж авдаг вэ?

-Энэ тал дээр Германтай маш идэвхтэй хамтран ажилласаар ирсэн. Гадаад хөрш, түнш улсуудаас ялгаатай нь ХБНГУ-ын улс төрийн намуудын дэргэдэх сангууд бүгд 1990 оноос эхлэн Монголд үйл ажиллагаа явуулж ирсэн. Бидний сайн мэдэх Конрад-Аденауэрын сан, Фридрих-Эбертийн сан, Ханнс-Зайделын сан манай улс төрийн намууд болон төр, засгийн байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллаж, ардчилсан төр, засаг, шүүхийн тогтолцоог бэхжүүлэх, улс төр, хууль эрх зүйн боловсрол, хэвлэл мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгоход зөвлөгөө өгөх, сургалт явуулах, тэтгэлэг олгох чиглэлээр ажилласаар байна. Германы Ногоон намын Хайнрих-Беллийн сан ч бурхны шашны уламжлалт соёл, өв уламжлалыг сэргээхэд хамтран ажиллаж байсан юм билээ. ТББ-ын шугамаар арвин туршлага хуримтлуулсан байна.

### -Монгол-Германы боловсролын салбарын хамтын ажиллагааны хүрээнд монгол оюутнуудыг анх 1926 онд Герман руу илгээж байсан. Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилсан "Илгээлт-2100" тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн онд 39 оюутан тэнд суралцахаар явлаа. Үүнийг боловсролын салбарт хийж буй дараагийн нэг алхам гэж ойлгож болох уу?

-Боловсролын салбарын тухайд дээр ганц нэг жишээ дурдсан. Соёл, боловсролын салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр 1997 онд байгуулагдсан. Улаанбаатар хотод Германы Гёте институт албан ёсоор үйл ажиллагаа явуулж байна. Бонн хотын их сургуулийн дэргэд Монгол судлалын тэнхимтэй, Берлин хотын Хумболдтын их сургууль, Лайпцигийн их сургуульд монгол судлаач профессор тус тус



ажилладаг. 2022 оны байдлаар, 769 монгол оюутан Германд суралцаж байсан баримт бий. Түүнчлэн 220 орчим залуус мэргэжлийн боловсрол эзэмшихээр сурч байна. Ерөнхийлөгчийн "Илгээлт 2100" тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 39 оюутан 2023 оноос эхлэн Дрезден хотноо суралцаж байна. Германы улс төрийн сангуудын шугамаар тэтгэлэгт хамрагдан суралцдаг оюутан ч цөөнгүй байна. Германы эрдмийн солилцооны алба (DAAD)-ны тэтгэлэг, GMIT сургуулийн нэрэмжит тэтгэлэг, мөн компанийн нэрэмжит тэтгэлгүүд ч бий юм билээ.

### -Ерөнхийлөгчийн түвшний энэ удаагийн айлчлалыг товчоор дүгнэвэл?

-Өнгөрсөн 50 жил, түүний дотор ардчиллын 30 гаруй жилийн харилцаа хамтын ажиллагаа чамлалтгүй хөгжсөн. Хоёр улс "Харилцааны үндсийн тухай Монгол Улс, ХБНГУ хоорондын хамтарсан тунхаглал"-ыг 1995 онд байгуулсан. Түүндээ харилцааны үндсэн зарчим, хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлсон. 2008 онд "Иж бүрэн түншлэлийн харилцааны тухай Монгол Улс, ХБНГУ хоорондын хамтарсан тунхаглал"-д гарын үсэг зурсан. Энэ хоёр чухал эрх зүйн баримт бичиг манай хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны чигийг зааж ирсэн. Судлаачийн хувьд хэлэхэд, энэ удаагийн айлчлалын хамгийн том үр дүн бол хоёр орны харилцааг шат ахиулж, Стратегийн

түншлэлийн түвшинд хүргэсэн явдал байлаа. Өнгөрсөн 50 жилийн хамтын ажиллагааны ололтуудаа нэгтгэн дүгнэж, дараагийн 50 жилийн хамтын ажиллагааны чиг хараагаа тодорхойлохоор ХБНГУ-ын Холбооны Ерөнхийлөгч манай улсад ирсэн болов уу.

### -Өнгөрсөн онд манай улс НҮБ-ын гишүүн бүх оронтой дипломат харилцаа тогтоолоо. Манай улсын гадаад харилцаа урьд өмнөхөөсөө улам идэвхжих он жилүүд биднийг хүлээж байна гэж ойлгож болох уу. Гадаад харилцааны идэвхтэй хэлбэрийг хадгалсны давуу тал, үр дүн юу байж болох вэ?

-Залгамж чанараа хадгалсан, бие даасан, тэнцвэртэй, идэвхтэй, нээлттэй, олон тулгуурт, онолын хувьд прагматик гадаад бодлого явуулж ирсэн, явуулсаар ч байна гэдгийг би байнга бичдэг, ярьдаг, ухуулдаг.

Монгол Улсын гадаад харилцаа бол маш амжилттай яваа салбар юм. Гадаад бодлогын бүх чиглэлд тэнцвэрийг маш сайн хадгалж байгаагийн илэрхийлэл болсон олон айлчлалыг 2023 онд хэрэгжүүлсэн. Тэнцвэр хадгална гэдэг нь хоёр хөрш болон гуравдагч хөршийн харилцаа тэнцвэржсэн, хоёр хөршийн харилцаа хоорондоо тэнцвэртэй байх юм. Мөн олон талт хамтын ажиллагаа хоёр талын харилцааны сүүдэрт орчхоогүй урагшилсаар байгааг би тодотгон тэмдэглэдэг. 2024 оны тухайд, дэлхийг Монголд авчрах чиглэлээр түлхүү ажилласан жил боллоо.

## Д.Гэрэлмаа: Монгол Улс, Швейцарын Холбооны Улсын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх өргөн боломж бий

Монгол Улс, Швейцарын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ой тохиож буйтай холбогдуулж Монгол Улсаас Швейцарын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Д.Гэрэлмаатай ярилцлаа.

**-Өнгөрсөн 60 жилийн хугацаанд Монгол, Швейцарын дипломат харилцаа хэрхэн өрнөсөн болон хамтын ажиллагааны ололт амжилт, түүхэн онцлог үйл явдлын талаар та мэдээлэл өгнө үү?**

-Монгол Улс 1961 онд НҮБ-д бүрэн эрхт гишүүнээр элссэний дараа барууны орнуудаас анх ИБУИНХУ-тай 1963 онд дипломат харилцаа тогтоож, улмаар 1964 онд Швейцар, Финланд, Австри, Швед Улстай харилцаа тогтоосон нь Монгол Улсын гадаад бодлого, олон улсын тавцан дахь нэр хүндийг бэхжүүлэхэд чухал түлхэц болсон. Хэдийгээр Монгол, Швейцар улс нь дипломат харилцаа тогтоосон ч 1990-ээд оны эхэн хүртэл хоёр улсын шууд харилцаа хязгаарлагдмал байв.

Ингээд 1990-ээд оны дунд үеэс хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлсэн олон салбарын гэрээ хэлэлцээрийг байгуулж, хоёр улсын баримталж буй зарчим, үнэт зүйлс, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх яриа хэлэлцээ хийх өргөн боломжийг бүрдүүлсэн дээд, өндөр түвшний харилцан айлчлалыг хэрэгжүүлж ирсэн нь өнөөгийн бидний тогтвортой, урагштай, үр дүнтэй харилцааг хөгжүүлэх эхлэл болжээ.

Өнгөрсөн 60 жилийн хугацаанд хөгжүүлсэн Монгол, Швейцарын харилцаа нь хоёр улсын нийтлэг эрх ашгийг хамгаалан бэхжүүлэхийн төлөө харилцан ойлголцол, тогтвортой хамтын ажиллагааны урт замнал юм. Дипломат харилцааны түүхэн ойг тэмдэглэж буй энэ үед бид хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг цаашид улам олон салбарт өргөжүүлэн хөгжүүлэх боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.

Энэхүү 60 жилийн ойн хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар Швейцарын Хол-

бооны Улсын Ерөнхийлөгч Виола Амхерд Монгол Улсад энэ оны 8 дугаар сард төрийн айлчлал хийлээ. Энэ нь Швейцарын Холбооны Улсаас Ерөнхийлөгчийн түвшинд анх удаа хэрэгжүүлсэн түүхэн айлчлал болсон гэдгийг тодотгох хэрэгтэй байх. Мөн энэ оны 5 дугаар сард Швейцарын Үндэсний зөвлөл буюу Парламентын гишүүн, Гадаад харилцааны хорооны дарга Лорен Верли манай улсад айлчилсан нь хоёр улсын парламентуудын хамтын ажиллагааг бэхжүүлсэн чухал айлчлал болсон юм.

**-Хоёр орны хамтын ажиллагааны чухал салбар юу вэ. Сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн талаар дурдана уу?**

-Монгол, Швейцарын хамтын ажиллагаа олон салбарт өргөжин тэлж байна. Хоёр улсын худалдаа, эдийн засгийн харилцаа тогтвортой хөгжиж, манай улсаас Швейцарт жилдээ 1 тэрбум ам.долларын алт экспортолж буй нь манай нийт экспортын 8.2 хувийг эзэлдэг. Манай хоёр улсын соёлын харилцаа улам бүр бэхжиж ирсэн. Швейцарт Монголын баялаг өв соёлыг харуулсан олон үйл ажиллагааг зохион байгуулдаг. Энэ нь соёл хоорондын харилцан ойлголцлыг бэхжүүлдэг.

Монголын түүх, нүүдэлчдийн өв уламжлалын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх хүрээнд Швейцарын хамгийн том урлагийн музей болох Цюрих хотын Риетбергийн музейд 2025-2026 онд хамтарсан үзэсгэлэн гаргаж, улмаар Баруун Европ болон дэлхийн алдартай музейн үзмэрүүдийг дэлгэн үзүүлэхээр ажиллаж байна. Энэхүү үзэсгэлэн нь Монгол Улсын Евроазийн соёл,



худалдаанд үзүүлсэн нөлөө, байр суурийг онцолж, Монголын түүхэн замнал, орчин үеийн онцлогийг харуулах зорилготой.

Соёлын харилцааны нэгэн адил боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа, оюутан солилцоо нь Монгол, Швейцарын харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Монгол Улс 1990-ээд онд ардчилал, зах зээлийн эдийн засагт хүрэх замд Швейцарын талаас үзүүлсэн дэмжлэг тусалцаанд бид талархдаг. Швейцар Улс 2000-аад оны эхэн үеэс манай улсад хөгжлийн тусламж санал болгож, Монгол Улсын хөгжилд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж ирсэн чухал түнш юм.

Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийг 2004 онд Улаанбаатар хотноо байгуулж, 2006 онд Монгол Улсыг Швейцарын хөгжлийн албан ёсны тусламж авах орнуудын жагсаалтад оруулсан нь тус улс манай улсын тогтвортой хөгжлийг дэмжихэд тууштай зүтгэж байгаагийн илрэл байв.

Мөн 1990-ээд оны сүүлчээс Швейцарын шилдэг эмч, мэс заслын эмч нар жил бүр Монгол Улсад ирж, өвчтөнүүдийг оношлох, эмчлэх, монгол эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах, мэргэжлийн заавар

зөвлөгөөг өгч ирсэн нь тэдний ур чадварт ихээхэн түлхэц болсныг дурдах нь зүйтэй. Энэхүү хамтын ажиллагаа нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандартыг сайжруулах зогсохгүй манай хоёр үндэстний найрамдлыг бэхжүүлэх, мэдлэг туршлагаа хуваалцах боломжийг бүрдүүлсэн юм.

Монгол Улс эдийн засгийн өсөлтийг хангах асар их нөөц баялагтай. Тогтвортой хөгжилд онцгой анхаарч байгаа Монгол Улс байгалийн баялгаа хөгжүүлэх, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэл, дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх боломжийг өргөжүүлэхэд гадаадын хөрөнгө оруулагчдыг татах сонирхолтой байдаг. Тиймээс эдийн засгийн харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Бидний хамтын ажиллагааны гол зорилго Швейцарын өндөр технологийн хөрөнгө оруулалтыг Монголд татах, улмаар инновацыг нэвтрүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Түүнчлэн Монгол Улс хөдөө аж ахуй эрхэлдэг орны хувьд эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан өндөр хөгжсөн Швейцар улстай хамтран ажиллаж, бодит үр дүнд хүрэхийг зорьж байна.

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2024 оны 1 дүгээр сард Давос хотноо Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад оролцох үеэрээ Швейцарын Холбооны Ерөнхийлөгч В.Амхердтэй уулзаж санал солилцсон. Талууд хоёр улсын хамтын ажиллагааны талаар ярилцсаны дотор өвлийн спорт, аялал жуулчлалын чиглэлээр нэр хүндтэй, баялаг туршлагатай Швейцар улстай хамтран ажиллаж, өвлийн аялал жуулчлалын салбараа хөгжүүлэх боломжийн талаар дурдсан. Монгол Улсын Аялал жуулчлалын хөгжлийн төв, Швейцарын Аялал жуулчлалын байгууллага хоорондын 2023 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэн Монгол, Швейцарын аялал жуулчлалын байгууллагууд хоёр орны аялал жуулчлалын салбарын хамтын ажиллагааг хөгжүүлэх, жуулчны тоог нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах юм.

Түүнчлэн энэ оны 9-10 дугаар

сард зохион байгуулсан Швейцарын гурав дахь том үзэсгэлэн "Foire du Valais"-д Монгол Улс хүндэт зочноор оролцлоо. Монголын соёлын баялаг өв, аялал жуулчлалын онцлог газруудыг швейцар иргэдэд танилцуулах, сурталчлах сайхан боломжийг олгож байгаа энэ үзэсгэлэн манай хоёр улсын соёлын харилцаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах нь дамжиггүй.

Монгол Улс Швейцарын Холбооны Улсыг ардчиллын үлгэр жишээ орон гэж үзэж, ардчилсан тогтолцоогоо тус улсын жишгээр хөгжүүлэхийг эрмэлздэг. Тогтвортой хамтын ажиллагаа, мэдлэг туршлага хуваалцах замаар бид Монголын ардчилсан тогтолцоо, засаглалыг сайжруулж чадна гэдэгт итгэлтэй байна. Бидний хамтын ажиллагаа ирэх жилүүдэд бүх салбарт амжилттай хөгжиж, дэлхий дахины тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулна.

**-Монгол, Швейцарын харилцааны хэтийн төлөвийг та хэрхэн тодорхойлж байна вэ?**

-Монгол, Швейцарын харилцааны ирээдүй, хэтийн төлөвийг өөдрөгөөр харж байна. Дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойг тэмдэглэж байгаа энэ үед олон салбарын харилцааг бэхжүүлэх өргөн боломж байгаад эргэлзэхгүй байна. Бид өөрсдийн давуу талаа ашиглаж, инновацыг хөгжүүлэн, иргэд хоорондын харилцааг урагшуулснаар хоёр талын хамтын ажиллагаа шинэ түвшинд хүрнэ гэдэгт итгэлтэй байна.

Хоёр улсын харилцааг өргөжүүлэхэд худалдаа, хөрөнгө оруулалт, боловсрол, соёл урлаг, тогтвортой хөгжил зэрэг салбарт хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлэн бэхжүүлэх нь миний хувьд эн тэргүүний зорилт юм. Эдийн засгийн харилцаагаа бэхжүүлэх нь инновац, бизнес эрхлэх боломжийг бүрдүүлнэ. Боловсрол, эрдэм шинжилгээний хамтын ажиллагааг идэвхжүүлэх нь олон талын ач холбогдолтой. Уран бүтээлийн үзэсгэлэн, урлагийн тоглолт зохион байгуулах замаар соёлын дипломат харилцаа, харилцан ойлголцлыг дэмжих нь зүйтэй.

Тогтвортой хөгжил, байгаль орч-

ны салбарын хамтын ажиллагааг хоёр талын харилцааны гол тулгуур болгохыг мөн эрмэлзэж байна. Монгол, Швейцар улсууд шилдэг туршлага, шинэлэг санаа, технологийг хуваалцсанаар уур амьсгалын өөрчлөлт, агаарын болон хөрсний бохирдол зэрэг байгаль орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломжтой.

Сэргээгдэх эрчим хүч, байгаль хамгаалах, эко аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах нь бай-



галь орчноо хамгаалах, ногоон хөгжил, тогтвортой амьжиргааг бий болгох давуу талтай юм.

Монгол, Швейцарын харилцааны ирээдүйг товчхондоо түншлэл, шинийг эрэлхийлэх, харилцан хүндэтгэл гэж би хэлэх байна. Нийтлэг үнэт зүйлс, хүсэл эрмэлзэлдээ тулгуурлан бид сорилт бэрхшээлийг даван туулж, улс орон, ард түмэндээ илүү цэцэглэн хөгжсөн, тогтвортой ирээдүйг цогцлооно гэдэгт итгэж байна.

Найрамдал, хамтын ажиллагаа, хамтын хөгжил цэцэглэлтэд суурилсан хоёр орны харилцааны дараагийн жарны түүхийг бид бүтээх болно.

**-Цаг гарган ярилцсан танд баярлалаа.**

## Ц.Баатар: Казахстан нь газар зүйн байршил, түүхэн уламжлалын хувьд ч бидний хамгийн ойрын гуравдагч хөрш

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн ажилтан Ц.Баатартай Монгол, Казахстан улсын харилцаа, хамтын ажиллагааны талаар ярилцлаа.

**-Монгол-Казахстаны хооронд дипломат харилцаа тогтоосноос хойш 30 гаруй жил өнгөрсөн байна. Хоёр орны харилцааны өрнөл, хөгжлийн жилүүдээс ямар чухал цаг үеийг та онцлох вэ?**

-1991 онд БНКаЗУ тусгаар тогтносны дараа Монгол Улс Казахстан улсыг хүлээн зөвшөөрч 1992 оны 1 дүгээр сарын 22-нд анх дипломат харилцаа тогтоожээ. Энэхүү харилцаанд чухал ач холбогдол өгч, мөн ондоо Элчин сайдын яамаа Алматы хотноо нээсэн. Сүүлд 2010 онд шинэ нийслэл Астана хот руу нүүж, тэндээ үйл ажиллагаагаа явуулж байна. Харин Казахстан улсын хувьд Дипломат төлөөлөгчийн газраа манай улсад 1997 онд, ЭСЯ-аа Улаанбаатар хотноо 2007 онд нээсэн. Хоёр улс хил залгаа бус ч Монгол Улсын хамгийн баруун цэгээс Казахстаны зүүн цэгийн хооронд 40 орчим км байгаа нь газар зүйн байршлын хувьд ч, түүхэн уламжлалын талаас ч гэсэн бидэнтэй хамгийн ойрын гуравдагч хөрш гэдгийг юуны өмнө тодотгон хэлэх нь зүйтэй байх.

Хоёр орны харилцаанд өнгөрсөн хугацаанд улс төрийн болон хууль тогтоох байгууллагуудын хоорондох харилцаа, хамтын ажиллагаа өрнөн хөгжсөн он жилүүд байлаа гэж онцлон дүгнэж болно. Хоёр орны төрийн болон хууль тогтоох байгууллагуудын дээд хэмжээний айлчлал тогтвортой урагшлан хөгжихийн хэрээр Засгийн газар, яам хоорондын харилцаа хамтын ажиллагаа өрнөн хөгжсөн. Тухайлбал, 2021 оны 10 дугаар сард Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Казахстан улсад албан ёсоор айлчилсан. Энэхүү айлчлал нь 1992 онд манай улс тус улстай дипломат харилцаа тогтоосноос хойш Монголын талаас Гадаад харилцааны сайдын түвшинд хэрэгжүүлсэн анхны албан ёсны айлчлал болсон.

Дээр дурдсан дээд хэмжээний олон удаагийн харилцан айлчлалын үр дүнд хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааны хууль, эрх зүйн орчныг зохицуулах 50 орчим гэрээ, хэлэлцээрийг байгуулсан. Эдгээрээс эдийн засгийн хамтын ажиллагааны чиглэлээр 1992 онд Монгол Улс, БНКаЗУ-ын хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон төлбөрийн тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр, Давхар татвараас харилцан чөлөөлөх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг онцлон дурдаж болох юм.

**-Манай хоёр орны дипломат харилцааны ижил төстэй онцлог тал нь юу вэ?**

-Манай хоёр орны дипломат харилцаа нь улс орнууд хоорондын найрсаг харилцааг хөгжүүлэх, энх тайван, аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулах үндсэн зорилгын хүрээнд ижил төстэй. Хоёр улс хоёулаа 1961 оны дипломат харилцааны тухай Венийн конвенцын дагуу дэлхийн бараг бүх оронтой дипломат харилцаа тогтоосон.



Хоёр улс гадаад бодлогын хувьд ч энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулж буй нь ч ижил төстэй гэж хэлж болох юм.

**-Хоёр улсын уламжлалт найрсаг харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд аль салбарын хамтын ажиллагаа сулавтар байна гэж та үзэж байна вэ?**

-Өнгөрсөн 30 гаруй жилд бид энэ улстай худалдаа, эдийн засгийн салбарт хамтран ажиллах өргөн боломж бий. Наад зах нь шатахууны хараат байдлаас бага ч болов гарах боломжтой. Баруун бүсийн босоо тэнхлэгийн ачаа, зорчигч тээврийн хурдны замын өгөөжийг нэмэгдүүлэх, Цагаан нуур чөлөөт бүсийг хөгжүүлэх, баруун бүс ялангуяа Баян-Өлгий аймгийн онцлогийг харгалзан аялал жуулчлал хөгжүүлэх, хөдөө аж ахуйн салбарт хөрөнгө оруулалт татах, хамтарсан жижиг, дунд үйлдвэр байгуулах зэрэг асар их нөөц боломжийг бид ашиглах хэрэгтэй. Дээр өгүүлсэн бүхэн хоёр талын уулзалт яриа хэлэлцээний түвшинд яригдсаар ирсэн.

**-Казахстан улсын Ерөнхийлөгч манай улсад айлчиллаа. Айлчлалын үр дүнг хэрхэн дүгнэв?**

-Казахстан улсын Ерөнхийлөгч К.Токаев өмнө нь Монголд хоёр удаа ирж байсан. Тодруулбал, 2006 онд Гадаад хэргийн сайдын хувьд, мөн 2013 онд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогчийн хувьд "Шинэ ардчилал" олон улсын хуралд оролцох зорилгоор Монгол Улсад айлчилж байсан тул манай орны талаар өргөн мэдлэг мэдээлэлтэй хүн юм. Айлчлалаар талууд ямар хэлэлцээ хийх вэ, ямар асуудлаар санал солилцож ажил хэрэг болгох түвшинд ойлголцох вэ гэдэг нь анхаарал татаж байлаа.

Энэхүү төрийн дээд хэмжээний айлчлалаар хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг шат ахиулж, "Стратегийн түншлэл"-ийн түвшинд хүргэн хөгжүүлэх түүхэн шийдвэрийг гаргалаа. Дахин хэлэхэд, Казахстан улс нь газар зүйн байршлын хувьд ч, түүхэн уламжлалын талаас ч гэсэн бидэнтэй хамгийн ойрын гуравдагч хөрш гэдгийг онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Цаашид Казахстан улс нь улс төр, эдийн засгийн хувьд ч гэсэн манай улсын чухал гуравдагч хөрш байх болно.

## Ж.Лхагвадэмчиг: Монгол, Бутаны харилцаа алсдаа буддын шашин, аялал жуулчлалаар өргөжих болов уу

Бутаны Хаант Улсын Цог Жавхлант Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчук 2024 онд Монгол Улсад төрийн айлчлал хийсэнтэй холбогдуулж, МУИС-ийн ШУС-ийн Антропологи, археологийн тэнхимийн багш, доктор Ж.Лхагвадэмчигтэй ярилцлаа.

**-Бутаны Цог Жавхлант Хаан манай улсад төрийн айлчлал хийв. Монголчууд Бутан орон, бутанчуудын тухай гойд сонирхож, эерэг сэтгэгдэлтэй үлдлээ. Харин та тус орны тухай ямар мэдээллийг онцлохыг хүсэж байна вэ?**

-Энэ улсын тухай яриагаа нэрээс нь эхлэх ёстой гэж бодож байна. Хималайн нуруунаас орж ирдэг их цасан шуурганы дуу чимээг луугийн хүрхрэлтэй зүйрлэж, ийм нэр авсан гэж өөрсдөө ярьдаг. Хүн амынх нь тоог 900 мянга орчим гэж хэлж болно. БНХАУ, БНЭУ гэсэн хоёр том хөршөөр хүрээлэгдсэн, далайд гарцгүй, хэмжээт эрхт хаант улс. 2008 онд Үндсэн хуулиа баталсан.

"Улс төрийн намтай, парламентын засаглалтай байна" гэж Үндсэн хуульдаа заасан. Парламентын сонгууль болоход улс төрийн намууд өрсөлдөж таарна. Гэтэл "Эзэн хаантай байхад, улс төрийн намаар яах юм бэ" гэж иргэд нь ярьж эхэлжээ. Хаан нь "Бид парламенттай, улс төрийн намтай байх ёстой" хэмээсэн. Тэгээд "Бутаны ардын ардчилсан нам", нөгөө нь уламжлалт орчуулгаар "Хотол чуулган хурсан" гэдэг намтай болсон. Бутаны иргэд өөрсдөө ямар нэг нам байгуулаагүй. Хааны зарлигаар ийнхүү улс төрийн хоёр намтай, парламентын засаглалтай болсон юм. Иргэдийнх нь 50 хувь нь төвөд үндэстэн, 35 хувь нь балба, үлдсэн хэсэг нь орон нутгийн хүмүүс юм. Бичгийн хувьд төвөд, хэлний хувьд зонхогоор ярьдаг.

Бутан, Төвөд, Монгол, монгол туургатанд буддын шашны Очир хөлгөний ёс өргөн дэлгэрсэн. Бутан иргэдийн олонх нь буддын шашин шүтдэг, төрийн шашин нь гэж үздэг.

**-Монгол, Бутан хоёр улс 2012 онд дипломат харилцаа тогтоосон. Түүнээс өмнө ямар харилцаатай байв?**

-Бутан улс 1971 онд НҮБ-ын гишүүн болсон. Дипломат харилцаа тогтоохоос өмнө БНМАУ-ын үед манай хоёр улс харилцаатай байсан юм билээ. БНМАУ-ын Буддын шашны тэргүүн номч мэргэн гавж, хамба С.Гомбожав тэргүүтэй зүтгэлтнүүд "Азийн буддистуудын энх тайвны бага хурал" гэх олон улсын байгууллага байгуулсан. Энэ байгууллагын V ерөнхий чуулган 1979 онд Улаанбаатар хотод болоход Бутан улсын төлөөлөгчид оролцохоор анх удаа Монгол Улсад ирсэн юм билээ. Үүний дараа 1982 онд "Азийн буддистуудын энх тайвны бага хурал"-ын VI чуулган Улаанбаатар хотод болсон. Бутаны хоёр төлөөлөгч мөн энэ чуулганд оролцсон. Гандантэгчинлэн хийдийн тухайн үеийн хамба лам Х.Гаадан гуай 1985 онд Бутан улсад болсон дээрх олон улсын байгууллагын чуулганд оролцохоор зочилж байв. Түүнчлэн Бутаны Цани ловон гэдэг хүн 1986 онд манай улсад айлчилсан байдаг. Дипломат харилцаа тогтоохоос өмнө Буддын шашин болон "Азийн буддистуудын энх тайвны бага хурал"-ын



шугамаар манай хоёр орны харилцаа явж ирсэн. Монгол Улс алсдаа Буддын шашин, аялал жуулчлалаар энэ оронтой харилцаагаа өргөжүүлэх болов уу гэж би боддог.

**-Бутаны хаан Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын онцлогийг та хэрхэн авч үзэж байна вэ?**

-Бутаны хаан энэ удаа эзэн хаангүй Монгол Улсад айлчилсан нь мэдээж сонирхолтой үйл явдалд тооцогдоно. Гэхдээ манайтай адил, эзэн хаангүй Сингапурт айлчилж байсан удаатай. Монгол Улсад бол анх удаа айлчиллаа. Энэ нь Бутан улсын хувьд Монгол Улстай харилцаагаа идэвхжүүлэх зорилготой байгаа нь тодорхой. Монгол Улсын хувьд Бутан төдийгүй цаашлаад Зүүн өмнөд Азид хандсан гадаад бодлогын алхмууд цаашид хийгдэнэ гэж би бодож байна.

**-Бутанчууд аз жаргалын индекс гэдгийг 1972 онд гаргасан. Аз жаргалын индекстэй болох нь бутанчуудад яагаад ач холбогдолтой гэж үзсэн юм бол?**

-Дэлхийн II дайны дараа хөгжил гэдэг ойлголт гарч ирсэн. Эхэн үедээ улс орны хөгжлийг тухайн орны дотоодын нийт бүтээгдэхүүн гэх мэт эдийн засгийн үзүүлэлтээр хэмждэг байв. Энэ улс өөрийгөө гадаад ертөнцөөс 1950-иад он хүртэл тусгаарласан байдаг. Харин БНЭУ-тай 1949 онд хамтын ажиллагааны гэрээ байгуулсан түүхтэй. Дөрөвдүгээр хаан Жигмэд Сэнгээ Гончиг нь "Улсаа хөгжүүлэе, бусдаас тусгаар байж болохгүй юм байна" гэж үзсэн гэдэг. Тэгэхдээ Азийн ихэнх улс орон шиг эдийн засагтаа тулгуурласан загвараар хөгжихөд Буддын шашин, соёл уламжлал, үндэстнийх нь онцлогт халтай гэж үзсэн юм билээ. Тэгээд өөрийн онцлогт тохирсон "Үндэстний аз жаргал" гэх бодлого гаргаж ирсэн. Түүнийг нь орчуулбал "Улс гүрний баяр цэнгэлийн цогийг хураах" гэсэн утгатай. Англи хэл рүү шууд орчуулбал ойлгогдохгүй тул 1970-аад оноос "Үндэстний аз жаргал" гэж томъёолсон. Энэ нэр томъёолол нь тухайн улсын хөгжлийн зам гэж Бутаны 4 дүгээр хаан хэлсэн байдаг. Тус улсын улс төрийн энэ бодлого сүүлийн жилүүдэд гадаад бодлого нь болсон. Тус улсын хувьд хүн ам цөөн, газар нутаг бага. Тийм болохоор олон улсын харилцаанд хамгийн аз жаргалтай үндэстэн гэх өөрийн улсын өнгө төрхийг үүсгэж байгаа нь энэ.

ОН ЦАГИЙН ТОВЧООН



**2023.01 сар**  
ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын орлогч дарга А.В.Гордеев

**2023.02 сар**  
БНСУ-ын Үндэсний Ассамблейн дэд дарга Ким Ён Жү

**2023.04 сар**  
ШХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Жан Мин

**2023.05 сар**  
Бүгд Найрамдах Киргиз Улсын Гадаад хэргийн сайд Жээнбек Молдоканович Кулубаев

**2023.06 сар**  
Гэгээн Ширээт Улсын Гадаад харилцааны асуудал эрхэлсэн Нарийн бичгийн дарга Пол Ричард Галлагер

**2023.06 сар**  
БНТУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ерөнхий нарийн бичгийн дарга Сейфуллах Хажымүфтүолу

**2023.06 сар**  
НҮБ-ын Зэвсэг хураах асуудал эрхэлсэн орлогч Ерөнхий нарийн бичгийн дарга Изуми Накамицу

**2023.07 сар**  
Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Парламентын доод танхим Лок Сабхагийн дарга Ом Бирла

**2023.07 сар**  
Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий захирал Тедрос А.Гебрейесус

**2023.09 сар**  
Саудын Арабын Хаант Улсын Засгийн газрын гишүүн, Төрийн сайд Эрхэм дээд Ханхүү Турки бин Мухаммад бин Фахд Аль-Саудыг Фумвихан

**2023.09 сар**  
БНАЛАУ-ын Үндэсний Ассамблейн дарга Сайсумпон Фумвихан

**2023.10 сар**  
ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн тэргүүн Мартин Шульц

**2023.10 сар**  
ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга, Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Оросын хэсгийн дарга В.В.Абрамченко

**2023.10 сар**  
Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Батлан хамгаалахын сайд Фам Ван Зианг

**2024.02 сар**  
ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга Алексей Логвинович Оверчук

**2024.03 сар**  
БНАСАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Пак Мён Хо

**2024.03 сар**  
Бүгд Найрамдах Беларусь Улсын Гадаад хэргийн сайд С.Ф.Алейник

**2024.04 сар**  
Бүгд Найрамдах Киргиз Улсын Парламент Жогорку Кенешийн дарга Нурланбек Шакиев

**2024.04 сар**  
Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн сайд Дэвид Камерон

**2024.05 сар**  
НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч бөгөөд Цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын суурь конвенцын Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Ибрахим Тио

**2024.08 сар**  
АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Энтони Блинкен

**2024.08 сар**  
Дэлхийн эмэгтэйчүүдийн чуулга уулзалтад оролцож буй НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч Амина Мохаммед

**2024.08 сар**  
Оманы Султант Улсын Гадаад хэргийн сайд Сайид Бадр Бин Хамад бин Хамуд Аль-Бусайди

**2024.09 сар**  
БНХАУ-ын дэд дарга Хань Жөн

**2024.10 сар**  
Европын сэргээн босголт, хөгжлийн банкны Ерөнхийлөгч Одиль Рено-Бассо

**2024.10 сар**  
Австралийн Холбооны Улсын Парламентын Сенатын танхимын Ерөнхийлөгч Сюзан Лаянс




Элчин сайд Д.Ганболд

## Ямар ч бутан хүнтэй уулзахад “Бид монгол гаралтай” гэх юм билээ

Бутанд анх очиход хамгийн түрүүнд Хималайн өндөр уулсыг онгоцноос олж харж байлаа. Тухайн үед онгоц огцом доошлон, уулс дундуур нисэж газардах нь содон санагдсан. Бутанд буухад монголчуудтай төстэй хүмүүсийн найрсаг харилцаа, ёс жаяг, хувцас хунарыг хараад нутагтаа ирсэн юм шиг санагдаж байв. Ялангуяа, халуу дүүгсэн Энэтхэгээс очсон болоод ч тэр үү сэрүүн салхи зөөлнөөр үлээгээд таатай мэдрэмж төрж байлаа.

Хималайн нурууны өвөрт орших Бутан орон зундаа хэт халуун биш атлаа өвөлдөө өнтэй, дулаахан. Жилийн дундаж температур 15–25 хэм. Уулзсан эрчүүдийн дунд Дорж, Цэрэн, эмэгтэйчүүдийн дунд Дулмаа, Бумаа нэртэй хүн олон байсан нь сэтгэлд ихэд дотно санагдаж билээ. Бутаны үндэсний соёл урлаг, уран зохиол, шашин шүтлэг, зан заншил, үндэсний хувцаслалт, сүм хийдийн зан үйл нь манай үндэсний соёлын хөгжлийн хэв загвартай төстэй болохыг тэнд байхдаа анзаарсан. Ямар ч бутан хүнтэй уулзахад “Бид монгол гаралтай” гэх юм билээ. Бутан хүүхдүүд төрөхдөө бидэнтэй ижил хөх толботой төрдөг гэсэн. Бутанчууд сүүтэй



цай ууж, боов боорцог идэж, сарлагийн сүүгээр хийсэн цагаан идээг хоол хүнсэндээ их хэрэглэдэг. Үндэсний спорт нь сурын харваа юм.


Дэлхийд нийт 34, тэр дундаа Азид 4 хаант улс байдаг. Монгол Улсын нэн шинэ түүхэнд 1970-аад онд Ираны Шах, 1995, 2007 онд Кувейтийн Эмир тус тус айлчилж байв. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн урилгаар 2024 онд Бутаны

Хаант Улсын Цог Жавхланта Хаан Жигмэ Гэсэр Намжил Ванчук, хатан Гялцэн Жэцүн Пема нар манай улсад анх удаа айлчиллаа. Энэ нь манай оронд айлчилж буй 3 дахь улсын хаан гэдгээрээ онцлог. Манай хоёр орон дипломат харилцаа тогтоосноос хойш хэрэгжүүлсэн энэхүү дээд хэмжээний айлчлал нь хоёр орны харилцаанд тэмдэглүүштэй, онцгой үйл явдал юм.

Зочин

## Кубын удирдагч асан Раул Кастрогийн охин Мариэла Кастро Монгол оронд

Би сургуульд байхдаа анх удаа монгол орны тухай сонсож байлаа. Гэхдээ Монголын тухай илүү ойроос сонсож, гүн сэтгэгдэл төрүүлсэн нь мэдээж аав юм. Аав маань Монголд зочилсныхоо дараа, Кубадаа очоод танай улсын талаар маш их зүйл ярьсан. Бидэнд олон зураг үзүүлж, үзсэн харсан зүйлсээ ярьж өгч байв. Монголд ирээд монголчуудын амьдралыг дэргэдээс нь харсан нь маш сонирхолтой байсан гэсэн.



Төр засгийн тэргүүн Ю.Цэдэнбал, Р.Кастро нар албан ёсны хэлэлцээний үеэр, Улаанбаатар хот, 1970 он



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Кубын удирдагч асан Раул Кастро Рустай уулзав. Хавана хот. 2023 он

Түүнд Монгол Улс, хүн ард нь, нэн ялангуяа монголчуудын зочломтгой зан онцгой сэтгэгдэл төрүүлсэн юм билээ. Аав маань хүн төрөлхтний түүхийг шимтэн үздэг хүн байсан. Тэр үед би ааваасаа Монголын тухай үнэхээр ихийг сонсож, олж мэдсэн л дээ.

Харин миний хувьд, Монголд удаагүй ч нэн түрүүнд, нүүдлийн мал аж ахуйн соёлоо хадгалж үлдсэн нь надад таалагдсан. Барууны соёл дэлхийд даяарчлагдаж байгаа ч монголчууд өөрсдийн хэл соёл, уламжлал, ёс заншлыг хадгалж үлдсэн нь гүн сэтгэгдэл төрүүлж байлаа. Танай улсын хүн амын ихэнх хэсэг нь одоо ч нүүдлийн

аж амьдралаар амьдарч байгаа нь онцгой юм. Мөн танай улсын эмэгтэйчүүдийн байгууллага намайг маш ихээр гайхшруулсныг би энд онцлох байна. Монголын Эмэгтэйчүүдийн холбооны түүхэн үйл хэрэг 1924 онд эхэлсэн ч 100 жилийн ойтойгоо золгож байгаа ажээ. Эмэгтэйчүүдийн холбооны үйл хэрэг ингэж тасралтгүй үргэлжлэхдээ түүхэн, шинэ нөхцөл байдалд үндэслэн өмнө хийж бүтээснээ бэхжүүлсээр иржээ.

Нийгэм дэх эмэгтэйчүүдийн хөгжил дэвшлийн үзүүлэлтээс нь би монгол эмэгтэйчүүд дорвитой, бахадмаар өсөн дэвжиж байгааг олж харлаа.

Доктор, дэд профессор Б.Цэнгэлхам:

## Монгол морь нутгаа тэмцэж гүйсэн гайхамшигт түүх



байна. Монгол Улс манай улсаас юу л хэрэгтэй байна, түүнийгээ нэрэлхэлгүйгээр хэлээд аваарай. Бид хамтдаа хөгжиж дэвших учраас манай эд баялаг бол танайх гэсэн үг. Хэрвээ нутаг орондоо хэрэгтэй гэвэл манай одос үхрээс авч өсгөж туршаарай" хэмээн хэлж байжээ.

Тухайн үед бэлгийн малын эхний ээлжийг хүргэсэн Л.Мажигсүрэн, Г.Мягмаржав нарын ахмад дайчид дурсамжаа үлдээсэн нь бий. Тэрхүү дурсамжид "Бид 10 дахь хоног дээрээ Хятад, Вьетнамын хил дээр вагоноо сольсон юм. Вьетнамын вагон жижиг, зам нарийн. Тэр зогсоол дээр хонгор морины ногт мултарч, бид гүйцэлгүй хойд талын модтой уул руу алдчихсан. Хонгор морь эх орноо зорин гүйсээр ирэхэд хилийн цэргүүд тороо хайчлаад оруулсан гэдэг. Тэр морь Хятадын Шар мөрөн, Хөх мөрнийг гатлаад, араатан амьтны савраас мултарч эх орондоо ирсэн байж билээ.

Энэ үе нь 1959 оны 11 дүгээр сарын 20-дын үе байсан. Морь маань 1960 оны 4, 5 дугаар сарын заагаар өвөлжөөнийхөө орчимд тун их туйлдсан, шарх сорвиндоо баригдсан юм ирсэн гэж дуулдсан. Очиж үзмээр санагдсан ч бага даргад олдох тийм боломж гэж юу байх билээ. Вагоноор 10 хоног явж хүрсэн замыг хагас жилийн дотор туулаад ирдэг монгол адуу агуу шүү.

Манай хоёр орны харилцаа бол ард түмний харилцан ойлголцол, итгэлцэл, он удаан жилийн нөхөрлөлд тулгуурласан бат бэх үндэс суурьтай. Олон жилийн дайнд нэрвэгдсэн Вьетнамын эдийн засаг туйлын хүнд байсан учраас ах дүү социалист орнууд түүний дотор Монгол Улс 1950-иад оны дунд үеэс эхлэн Вьетнамын ард түмэнд эд материалын тусламж үзүүлж эхэлсэн.

БНМАУ-ын Засгийн газар Вьетнамын ард түмэнд туслах комиссыг 1958 онд байгуулсан юм билээ. 1958 оны 9 дүгээр сард болсон МАХН-ын Төв хорооны хурлаас анхны бэлгийн мал хүргэх ажлыг протоколд тэмдэглэж, Намын Төв хорооны гишүүн, БНМАУ-ын ХШЯ-ны сайд Ж.Жамьянг комиссын даргаар томилсон байдаг. 1959 онд Ю.Цэдэнбал тэргүүтэй БНМАУ-ын нам, засгийн төлөөлөгчид БНАВУ-д айлчлахдаа 100 мянган толгой малыг бэлэг болгон өгөхөөр шийдвэрлэсэн юм. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1959 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн тогтоолоор 1959-1965 онд Вьетнамд нийлүүлэх буцалтгүй тусламжийн 100 мянган толгой малаас үхэр 54, тэмээ 21, адуу 364 толгой, хонь 13748, ямаа 813 толгой, бүгд 15000 толгой малыг 2,3 сая төгрөгийн зардалд багтаан Вьетнамын талд 1959-1982 онд шилжүүлэн өгчээ.

Монгол Улсаас Вьетнамд МАА-н салбарыг хөгжүүлэх чиглэлээр ийнхүү чин сэтгэлээр тусалсан нь Вьетнамын ард түмэнтэй ах дүүгийн барилдлагыг улам бататган гүнзгийрүүлсэн юм. Энэ үед Вьетнамын Ерөнхийлөгч Хо Чи Мин "Бидэнд ах дүү монгол нөхөд тусламжийн халуун гараа сунгаж, чин сэтгэлийн асар их тусламж үзүүлж



Бэлгээ хүргэж ирээд, нэг морь алдсанаа илтгэхэд "Тоогүй юм болж, чамтай хариуцлага тооцох болжээ" гээд намын байгууллагын товчооны хурлаар оруулж, сануулга өгч байсан" хэмээн дурсан бичсэн байдаг.

## Д.Соулия: Монголын зун, монголчуудын зүрх сэтгэл тийм халуун гэж огт төсөөлөөгүй



Би хэзээ ч цас харж байгаагүй. Анх удаа хүйтэн уур амьсгалыг мэдрээд ихэд гайхсан. Зарим өдөр хувцсаа 3-4 давхарлаж өмсдөг байлаа.

Гэрийнхэндээ "Өнөөдөр -40 хэмийн хүйтэн байна" гээд цас харуулахаар тэд хэлэх үггүй болж, "Яаж наана чинь хүмүүс амьдардаг байна аа" гээд гайхдаг байсан. Одоо ч өвөл болоход хэцүү санагддаг. Гэсэн хэдий ч Монголын зун, монголчуудын зүрх сэтгэл тийм халуун гэж огт төсөөлөөгүй.

Зуны амралтаараа Хөвсгөл нуурт очсон. Үнэхээр үзэсгэлэнтэй нуур. Гэхдээ нарны тос авч яваагүйгээс хурц наранд түлэг-

дээд, арьс маань хорсоод, бов бор болчихсон. Монгол оронд байгалийн үзэсгэлэнт газар олон. Богд уул маш сүрлэг. Найзуудтайгаа Богд уул руу алхах дуртай. Явган алхаж, байгалийн сайхныг мэдэрч байгаа нь энд байх хугацаанд цагийг хамгийн сайхан өнгөрүүлсэн дурсамжуудын нэг байх болно.

Эхний жил МУИС-д хэлний бэлтгэлд сурч байхад амархан санагдсан. "Энэ бол ширээ, энэ бол самбар" гээд төвөггүй сурч байлаа. Харин ХААИС-д сурахад шал өөр, ялгаа гарч ирсэн. Хэлний бэрхшээлтэй тулгарсан. Учир нь биднийг хэлний бэлтгэлд сурах үед цар тахал дэгдэж, монгол хэлийг цахимаар 4 сар, танхимаар

4 сар сурсан. Монгол хэлний өгүүлбэрийн бүтэц их хэцүү. Гэхдээ хэл сурахад тухайн хэлийг өдөр бүр хэрэглэх, байнга хүмүүстэй харилцан ярих нь хамгийн чухал юм билээ.

Хоёр болон гуравдугаар курсийн дадлагаар хөдөө явж, монгол гэрт амьдарч, гал түлж үзсэн. Монголын үндэсний баярууд их гоё. Төгсөхөөсөө өмнө наадам үзэх хүсэлтэй байгаа. Цагаан сараар айлд очиж, зөндөө бууз идсэн.

Найзуудынхаа гэрээр зочилж, аав ээжтэй нь танилцаж дайлуулж байлаа. Улаанбаатарын ойролцоо Тэрэлжид очиж гурван ч удаа морь унасан. Байгалийн сайханд морь унаад явах сонирхолтой юм билээ. Лаост морь тийм ч элбэг биш болохоор морь унаж үзээгүй байсан л даа. Монголчуудын дээдлэн хайрладаг амьтан нь морь бол манайд заан байдаг.

Лаост ирсэн жуулчид заан их унаж үздэг. Мөн Тэрэлжид аялахдаа дэлхийд цөөхөн байдаг хоёр бөхтэй тэмээтэй зураг авахуулсан. Одоогоор тэмээ унаж үзээгүй ч явахдаа өмнө унаж үзнэ гэж боддог. Монгол малын мах сайхан амттай. Тиймээс мах идэх дуртай. Нутагтаа очоод энэ амтыг санах байх. Хамгийн амттай нь адууны мах. Цуйван хамгийн сайхан хоол. Хуушуур, бууз, хорхог гээд бүгдэд нь дуртай. ХААИС-д сурсных таван хошуу малын талаар өргөн мэдлэгтэй болж байна.

ХААИС төгссөн олон лаос оюутан маш сайн боловсрол эзэмшсэн байдаг. Өдөр бүр монголоор ярьж, шинэ мэдлэг олж авч, өөрсдийгөө сорьж байна. Монголд сурсан олон төгсөгч нутагтаа очин, улс эх орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулж яваа.

